

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа	2025 оны 01-р сарын 01-ний өдрөөс 2025 оны 12-р сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Компанийн нэр: “Говь” ХК УБГД: 9010001061 Үнэт цаасны код: MN00GOV03548 Албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар хот- 17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК Утасны дугаар: (+976) 7013-9977 Факс: (976)-70143081 И-мэйл: info@gobicashmere.com Веб сайт: info.gobi.mn Фейсбүүк: GobiCashmere Онлайн дэлгүүр: Дотоод: gobi.mn Гадаад: gobicashmere.com
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Ямааны ноолуурт цогц боловсруулалт хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	“Кэй Пи Эм Жи Аудит” ХХК
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	780,112,500
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Тайланг бэлтгэсэн мэргэжилтэн: М.Сэлэнгэ /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/ Хянасан: Б.Амарсайхан /Гүйцэтгэх захирал/

1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/		
1.1	Санхүүгийн байдлын үзүүлэлт		
	НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (мянган төгрөг) 2024 2025		
	Хөрөнгө		
	<i>Эргэлтийн хөрөнгө</i>		
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,326,046	2,804,394
	Урьдчилгаа төлбөр	3,512,304	3,944,115
	Дансны болон бусад авлага	9,404,878	5,490,244
	Бараа материал	122,708,175	124,806,536
		139,951,403	137,045,289
	<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>		
	Үндсэн хөрөнгө	146,412,229	134,499,342
	Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө	2,780,438	3,068,800
	Хойшлогдсон татварын хөрөнгө	5,661,214	6,541,951
	Бусад эргэлтийн бус хөрөнгүүд	11,472,217	21,093,186
		166,326,098	165,203,279
	Нийт хөрөнгө	306,277,501	302,248,568
	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		
	<i>Богино хугацаат өр төлбөр</i>		
	Дансны болон бусад өглөг	37,867,812	10,930,011
	Гэрээний өр төлбөр	2,129,778	2,044,536
	Богино хугацаат түрээсийн өглөг	1,103,295	1,404,476
	Орлогын албан татварын өглөг	381,026	1,712,320
	Богино хугацаат зээл	211,265,887	171,986,397
		252,747,798	188,077,740
	<i>Урт хугацаат өр төлбөр</i>		
	Урт хугацаат түрээсийн өглөг	1,922,734	1,494,543
	Урт хугацаат зээл	36,210,000	115,683,447
	Бусад урт хугацаат өглөг	-	1,355,833
	Хойшлогдсон татварын өглөг	13,939,844	17,793,063
		52,072,578	136,326,886
	Нийт өр төлбөр	304,820,376	324,404,626
	Эздийн өмч		
	Хувьцаат капитал	780,113	780,113
	Дахин үнэлгээний нөөц	43,777,386	42,416,645
	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	(12,119,789)	(35,936,297)
	Хуримтлагдсан алдагдал	(30,980,585)	(29,416,519)
	Нийт эздийн өмч	1,457,125	(22,156,058)
	Нийт өр төлбөр ба эздийн өмч	306,277,501	302,248,568

1.2	Орлогын тайлан																																																																					
	НЭГТГЭСЭН ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН (мянган төгрөг) <table><tr><th></th><th>2024</th><th>2025</th></tr><tr><td>Борлуулалтын орлого</td><td>247,026,317</td><td>246,187,537</td></tr><tr><td>Борлуулсан бүтээгдэхүүний өртөг</td><td>(138,552,341)</td><td>(127,901,880)</td></tr><tr><td>Нийт ашиг</td><td>108,473,976</td><td>118,285,657</td></tr><tr><td>Бусад орлого</td><td>3,649,691</td><td>22,051,504</td></tr><tr><td>Борлуулалт ба түгээлтийн зардал</td><td>(53,217,129)</td><td>(57,344,113)</td></tr><tr><td>Ерөнхий ба удирдлагын зардал</td><td>(24,908,151)</td><td>(24,507,306)</td></tr><tr><td>Бусад зардал</td><td>(6,919,419)</td><td>-</td></tr><tr><td>Үйл ажиллагааны ашиг</td><td>27,078,968</td><td>58,485,742</td></tr><tr><td>Санхүүгийн орлого</td><td>4,465,583</td><td>1,323,690</td></tr><tr><td>Санхүүгийн зардал</td><td>(33,118,100)</td><td>(54,912,106)</td></tr><tr><td>Татварын өмнөх ашиг / (алдагдал)</td><td>(1,573,549)</td><td>4,897,323</td></tr><tr><td>Орлогын албан татварын зардал</td><td>(2,083,660)</td><td>(4,693,998)</td></tr><tr><td>Тайлант жилийн цэвэр ашиг / (алдагдал)</td><td>(3,657,209)</td><td>203,325</td></tr><tr><td colspan="3">Бусад дэлгэрэнгүй орлого:</td></tr><tr><td colspan="3">Ашиг, алдагдал руу дараа үед дахин ангилагдах боломжгүй бусад дэлгэрэнгүй орлого:</td></tr><tr><td>Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөлөө</td><td>32,341,972</td><td>-</td></tr><tr><td>Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний татварын нөлөө</td><td>(8,085,493)</td><td>-</td></tr><tr><td colspan="3">Ашиг, алдагдал руу дараа үед дахин ангилагдах боломжтой бусад дэлгэрэнгүй орлого:</td></tr><tr><td>Гадаад дахь охин компаниудын цэвэр хөрөнгийн гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн зөрүү</td><td>(1,457,516)</td><td>(23,816,508)</td></tr><tr><td>Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого</td><td>22,798,963</td><td>(23,816,508)</td></tr><tr><td>Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого (алдагдал)</td><td>19,141,754</td><td>(23,613,183)</td></tr><tr><td>Нэгж хувьцаанд ногдох ашиг / (алдагдал) - төгрөгөөр</td><td>(5)</td><td>0.26</td></tr></table>		2024	2025	Борлуулалтын орлого	247,026,317	246,187,537	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(138,552,341)	(127,901,880)	Нийт ашиг	108,473,976	118,285,657	Бусад орлого	3,649,691	22,051,504	Борлуулалт ба түгээлтийн зардал	(53,217,129)	(57,344,113)	Ерөнхий ба удирдлагын зардал	(24,908,151)	(24,507,306)	Бусад зардал	(6,919,419)	-	Үйл ажиллагааны ашиг	27,078,968	58,485,742	Санхүүгийн орлого	4,465,583	1,323,690	Санхүүгийн зардал	(33,118,100)	(54,912,106)	Татварын өмнөх ашиг / (алдагдал)	(1,573,549)	4,897,323	Орлогын албан татварын зардал	(2,083,660)	(4,693,998)	Тайлант жилийн цэвэр ашиг / (алдагдал)	(3,657,209)	203,325	Бусад дэлгэрэнгүй орлого:			Ашиг, алдагдал руу дараа үед дахин ангилагдах боломжгүй бусад дэлгэрэнгүй орлого:			Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөлөө	32,341,972	-	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний татварын нөлөө	(8,085,493)	-	Ашиг, алдагдал руу дараа үед дахин ангилагдах боломжтой бусад дэлгэрэнгүй орлого:			Гадаад дахь охин компаниудын цэвэр хөрөнгийн гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн зөрүү	(1,457,516)	(23,816,508)	Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	22,798,963	(23,816,508)	Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого (алдагдал)	19,141,754	(23,613,183)	Нэгж хувьцаанд ногдох ашиг / (алдагдал) - төгрөгөөр	(5)	0.26
	2024	2025																																																																				
Борлуулалтын орлого	247,026,317	246,187,537																																																																				
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(138,552,341)	(127,901,880)																																																																				
Нийт ашиг	108,473,976	118,285,657																																																																				
Бусад орлого	3,649,691	22,051,504																																																																				
Борлуулалт ба түгээлтийн зардал	(53,217,129)	(57,344,113)																																																																				
Ерөнхий ба удирдлагын зардал	(24,908,151)	(24,507,306)																																																																				
Бусад зардал	(6,919,419)	-																																																																				
Үйл ажиллагааны ашиг	27,078,968	58,485,742																																																																				
Санхүүгийн орлого	4,465,583	1,323,690																																																																				
Санхүүгийн зардал	(33,118,100)	(54,912,106)																																																																				
Татварын өмнөх ашиг / (алдагдал)	(1,573,549)	4,897,323																																																																				
Орлогын албан татварын зардал	(2,083,660)	(4,693,998)																																																																				
Тайлант жилийн цэвэр ашиг / (алдагдал)	(3,657,209)	203,325																																																																				
Бусад дэлгэрэнгүй орлого:																																																																						
Ашиг, алдагдал руу дараа үед дахин ангилагдах боломжгүй бусад дэлгэрэнгүй орлого:																																																																						
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөлөө	32,341,972	-																																																																				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний татварын нөлөө	(8,085,493)	-																																																																				
Ашиг, алдагдал руу дараа үед дахин ангилагдах боломжтой бусад дэлгэрэнгүй орлого:																																																																						
Гадаад дахь охин компаниудын цэвэр хөрөнгийн гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн зөрүү	(1,457,516)	(23,816,508)																																																																				
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	22,798,963	(23,816,508)																																																																				
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого (алдагдал)	19,141,754	(23,613,183)																																																																				
Нэгж хувьцаанд ногдох ашиг / (алдагдал) - төгрөгөөр	(5)	0.26																																																																				

1.3	Өмчийн өөрчлөлтийн тайлан																																																																																														
	НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН (мянган төгрөг) <table> <tr> <th></th><th>Хувьцаат капитал</th><th>Дахин үнэлгээний нөөц</th><th>Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц</th><th>Хуримтлагдсан алдагдал</th><th>Нийт</th></tr> <tr> <td>2024 оны 01 сарын 01-ний үлдэгдэл</td><td>780,113</td><td>20,514,269</td><td>(10,662,273)</td><td>(28,316,738)</td><td>(17,684,629)</td></tr> <tr> <td>Нийт дэлгэрэнгүй орлого:</td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr> <td>Тайлант жилийн цэвэр алдагдал</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>(3,657,209)</td><td>(3,657,209)</td></tr> <tr> <td>Бусад дэлгэрэнгүй орлого</td><td>-</td><td>24,256,479</td><td>(1,457,516)</td><td>-</td><td>22,798,963</td></tr> <tr> <td>Эздийн өмчтэй холбоотой өөрчлөлт:</td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr> <td>Хуримтлагдсан ашиг уруу шилжүүлсэн</td><td>-</td><td>(993,362)</td><td>-</td><td>993,362</td><td>-</td></tr> <tr> <td>2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</td><td>780,113</td><td>43,777,386</td><td>(12,119,789)</td><td>(30,980,585)</td><td>1,457,125</td></tr> <tr> <td>2025 оны 01 сарын 01-ний үлдэгдэл</td><td>780,113</td><td>43,777,386</td><td>(12,119,789)</td><td>(30,980,585)</td><td>1,457,125</td></tr> <tr> <td>Нийт дэлгэрэнгүй орлого:</td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr> <td>Тайлант жилийн цэвэр ашиг</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>203,325</td><td>203,325</td></tr> <tr> <td>Бусад дэлгэрэнгүй алдагдал</td><td>-</td><td>-</td><td>(23,816,508)</td><td>-</td><td>(23,816,508)</td></tr> <tr> <td>Эздийн өмчтэй холбоотой өөрчлөлт:</td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr> <td>Хуримтлагдсан ашиг уруу шилжүүлсэн</td><td>-</td><td>(1,360,741)</td><td>-</td><td>1,360,741</td><td>-</td></tr> <tr> <td>2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</td><td>780,113</td><td>42,416,645</td><td>(35,936,297)</td><td>(29,416,521)</td><td>(22,156,060)</td></tr> </table>						Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нөөц	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан алдагдал	Нийт	2024 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	780,113	20,514,269	(10,662,273)	(28,316,738)	(17,684,629)	Нийт дэлгэрэнгүй орлого:						Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(3,657,209)	(3,657,209)	Бусад дэлгэрэнгүй орлого	-	24,256,479	(1,457,516)	-	22,798,963	Эздийн өмчтэй холбоотой өөрчлөлт:						Хуримтлагдсан ашиг уруу шилжүүлсэн	-	(993,362)	-	993,362	-	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	780,113	43,777,386	(12,119,789)	(30,980,585)	1,457,125	2025 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	780,113	43,777,386	(12,119,789)	(30,980,585)	1,457,125	Нийт дэлгэрэнгүй орлого:						Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	-	203,325	203,325	Бусад дэлгэрэнгүй алдагдал	-	-	(23,816,508)	-	(23,816,508)	Эздийн өмчтэй холбоотой өөрчлөлт:						Хуримтлагдсан ашиг уруу шилжүүлсэн	-	(1,360,741)	-	1,360,741	-	2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	780,113	42,416,645	(35,936,297)	(29,416,521)	(22,156,060)
	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нөөц	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан алдагдал	Нийт																																																																																										
2024 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	780,113	20,514,269	(10,662,273)	(28,316,738)	(17,684,629)																																																																																										
Нийт дэлгэрэнгүй орлого:																																																																																															
Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(3,657,209)	(3,657,209)																																																																																										
Бусад дэлгэрэнгүй орлого	-	24,256,479	(1,457,516)	-	22,798,963																																																																																										
Эздийн өмчтэй холбоотой өөрчлөлт:																																																																																															
Хуримтлагдсан ашиг уруу шилжүүлсэн	-	(993,362)	-	993,362	-																																																																																										
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	780,113	43,777,386	(12,119,789)	(30,980,585)	1,457,125																																																																																										
2025 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	780,113	43,777,386	(12,119,789)	(30,980,585)	1,457,125																																																																																										
Нийт дэлгэрэнгүй орлого:																																																																																															
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	-	203,325	203,325																																																																																										
Бусад дэлгэрэнгүй алдагдал	-	-	(23,816,508)	-	(23,816,508)																																																																																										
Эздийн өмчтэй холбоотой өөрчлөлт:																																																																																															
Хуримтлагдсан ашиг уруу шилжүүлсэн	-	(1,360,741)	-	1,360,741	-																																																																																										
2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	780,113	42,416,645	(35,936,297)	(29,416,521)	(22,156,060)																																																																																										

1.4	Мөнгөн гүйлгээний тайлан		
	НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН		
	(мянган төгрөг)		
		2024	2025
	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
	Тайлант жилийн цэвэр алдагдал	(3,657,209)	203,325
	Тохируулгууд:		
	Элэгдэл ба хорогдлын зардал	14,554,268	15,224,714
	Орлогын албан татварын зардал	2,083,660	4,693,998
	Хүүгийн зардал	28,966,791	30,730,295
	Хүүгийн орлого	(21,032)	(1,323,690)
	Хөнгөлөлттэй зээлийн дискаунтын нөлөө	3,000,620	4,025,494
	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	1,103,637	70,903
	Бараа материалын хасагдуулгын зардал (буцаалт), цэвэр	197,117	59,938
	Үндсэн хөрөнгө данснаас хассаны (олз) / гарз	60,004	(119,275)
		46,287,856	53,565,702
	Өөрчлөлт:		
	Дансны болон бусад авлага	(6,518,867)	20,124,871
	Урьдчилгаа төлбөр	1,358,657	(219,899)
	Бараа материал	19,615,985	(2,158,299)
	Дансны ба бусад өглөг	(5,048,402)	(9,049,329)
	Гэрээний өр төлбөр	457,354	(85,242)
		56,152,583	62,177,804
	Төлсөн орлогын албан татвар	(1,918,219)	(390,222)
	Төлсөн хүү	(24,506,337)	(26,291,212)
	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	29,728,027	35,496,370
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
	Хүлээн авсан хүү	21,032	1,323,690
	Үндсэн хөрөнгө борлуулснаас орж ирсэн мөнгө	25,055	174,768
	Үндсэн хөрөнгийн худалдан авалт	(15,206,659)	(1,420,385)
	Биет бус хөрөнгийн худалдан авалт	(5,889,178)	(801,195)
	Холбоотой талд өгсөн зээл	-	(20,000,000)
	Холбоотой талд өгсөн зээлийн эргэн төлөлт	-	10,000,000
		(21,049,750)	(10,723,122)
	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
	Авсан зээл (холбоотой талыг оролцуулаад)	1,248,559,876	1,101,012,639
	Гаргасан бонд	10,982,346	-
	Төлсөн бонд	-	(10,982,345)
	Төлсөн зээл (холбоотой талын зээлийг оролцуулаад)	(1,270,804,301)	(1,091,330,190)
	Төлсөн түрээсийн төлбөр	(1,098,962)	(1,293,414)
	Төлсөн ногдол ашиг	(355)	(291)
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(12,361,396)	(2,593,601)
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр (бууралт) / өсөлт		
	Гадаад дахь охин компаниудын гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн зөрүү	(1,457,516)	(23,816,508)
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл дэх ханшийн зөрүүний нөлөөлөл	(24,430)	115,209
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,491,111	4,326,046
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,326,046	2,804,394

1.1. 1.2.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт болон Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/
	 Кэй Пи Эм Жи Аудит ХХК Монгол Улс, Улаанбаатар-14240, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө 17, Блю Скай Тауэр, 602 тоот Утас : +976 7011 8101 Факс: +976 7011 8102 www.kpmg.com/mn Хараат Бүс Аудиторын Тайлан Говь Хувьцаат Компанийн Хувьцаа Эзэмшигчид болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд: Дүгнэлт Бид Говь ХК (цаашид “Толгой Компани” гэх) болон түүний охин компаниуд (цаашид хамтад нь “Групп” гэх)-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн саанхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд ба бусад тайлбар мэдээллүүдийг агуулсан тодруулгуудаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийлээ. Бидний дүгнэлтээр, энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Группийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн гүйцэтгэл болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд (цаашид “СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд” гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна. Дүгнэлтийн Үндэслэл Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн <i>Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага</i> хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (Хараат Бүс Байдлын Олон Улсын Стандарт үүнд хамаарна) (цаашид “НБЁЗОУСЗ-ийн Ёс зүйн Дүрэм” гэх) болон нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Монгол Улс дахь ёс зүйн зохих шаардлагуудын дагуу Группээс хараат бүс байж, НБЁЗОУСЗ-ийн Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна. Аудитын Гол Онцлох Зүйлс Аудитын гол онцлох зүйлс гэдэг нь бидний мэргэжлийн үнэлэмжээр тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал ач холбогдол бүхий зүйлс юм. Бид нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр аудитын гол онцлох зүйлсийг бүхэлд нь авч үзсэн ба дүгнэлт гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гараагүй болно.



Аудитын Гол Онцлох Зүйлс, Үргэлжлэл

Борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлт

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Тодруулга 22.1, мөн Тодруулга 2.12-т тусгагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгуудыг харна уу.

Гол онцлох зүйлс	Тэдгээрийг шийдвэрлэсэн аудитын арга хэмжээ
Аудитын Олон Улсын Стандартад борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлттэй холбоотой залилангийн эрсдэл аливаа байгууллагад зайлшгүй байдаг гэж үздэг. Бид бөөний борлуулалтын орлого оршин байх, үнэн зөв байх болон цаг хугацаанд нь бүртгэсэн эсэхэд уг эрсдэлийг авч үзсэн ба уг эрсдэлийг удирдлагад үүсч буй төлөвлөсөн санхүүгийн үр дүнд хүрэх шахалт эсвэл удирдлага нь бөөний борлуулалтын дүнг гүйвүүлэн ашиглаж шагнал урамшуулалд хүртэх эрсдэл байж болзошгүй гэж тодорхойлсон. Дээрх зүйлстэй холбоотойгоор бид бөөний борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлтийг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн гол онцлох зүйл гэж авч үзсэн.	Борлуулалтын орлогын хувьд гүйцэтгэсэн аудитын горимууд: - Бид удирдлагын зүгээс борлуулалт болон борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөх үйл явцад хэрэгжүүлж буй хяналтууд, тэр дундаа бөөний борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлтийн оршин байх, үнэн зөв байх болон цаг хугацаанд нь бүртгэх зэрэг хяналтуудыг шалгасан. - Бид Группийн хэрэгжүүлсэн бөөний борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөх бодлогыг удирдлагатай ярилцлага хийх, борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрч буй цаг хугацааг холбогдох стандартын шаардлагад нийцэж буй эсэхийг борлуулалтын гэрээнүүдээс түүвэр байдлаар сонгон хүргэлтийн нөхцөлүүдийг ойлгох үүднээс нягтлан шалгасан. - Борлуулалтын орлогыг зохих санхүүгийн жилд борлуулалтын гэрээний нөхцөлийн дагуу хүлээн зөвшөөрсөн эсэхийг шалгах үүднээс жилийн дуусгавар болох хугацааны үед хийгдсэн борлуулалтын ажил гүйлгээнүүдээс түүврээр сонгон авч бараа материалын зарлагыг илэрхийлэх баримтууд, борлуулсан бараа материалын хүргэлтийг худалдан авагч талаас хүлээн зөвшөөрсөн холбогдох баримт бичгүүдтэй тулган шалгасан. - Бид Групп болон түүний худалдан авагч нарын хооронд хийгдсэн борлуулалтын ажил гүйлгээнд тулган баталгаажуулалт хийх гэх мэт аудитын горимтуудыг хэрэгжүүлсэн. - Бид тайлант жилийн дараа үед хийгдсэн борлуулалтын буцаалтууд нь бодитой байсан эсэхийг шалгасан. - Бид орлого хүлээн зөвшөөрөх ердийн үйл явцаас гадуур борлуулалтын орлогын журналын бичилтүүд хийгдсэн эсэхийг шалгасан.



Бусад Мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээх юм. Бусад мэдээлэл гэдэгт жилийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба нэгтгэсэн санхүүгийн тайлан болон манай аудиторын тайлан үүнд хамаарахгүй болно.

Нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

Бусад мэдээлэлтэй уншиж танилцан, уг мэдээлэл нь нэгтгэсэн санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад олж авсан бидний ойлголттой материаллаг хэмжээгээр нийцэхгүй эсвэл материаллагаар буруу илэрхийлэгдсэн зүйлс байгаа эсэхийг шалгах нь нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бидний хүлээх үүрэг, хариуцлага юм. Хийж гүйцэтгэсэн ажлын хүрээнд бусад мэдээлэлд аливаа материаллаг буруу илэрхийлэл байна гэж үзвэл бид энэ талаар тайлагнах үүрэгтэй. Бусад мэдээлэлтэй холбоотойгоор бидэнд тайлагнах зүйлс байгаагүй.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Эгтгээдүүдийн Нэгтгэсэн Санхүүгийн Тайланд Хүлээх Үүрэг Хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн тайланг СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Алдаа, зальт ажиллагааны улмаас материаллагаар буруу илэрхийлэгдээгүй нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх үүрэг хариуцлагыг мөн удирдлага хүлээнэ.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлагын зүгээс Группийн тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх чадамжийг үнэлэн, шаардлагатай гэж үзвэл тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг нэгтгэсэн санхүүгийн тайланд тодруулж, Группийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан нэгтгэсэн санхүүгийн тайлангаа бэлтгэх үүргийг Группийн удирдлага хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Группийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хүлээнэ.



Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоог олж авах, бидний дүгнэлтийг агуулж буй аудиторын тайланг танилцуулах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт хэдий ч АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь бүхий л материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ уг нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн гаргах мэдээлэл хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр хүлээгдэж байвал материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу аудит хийх үед мэргэжлийн үнэлэмж гаргах, мэргэжлийн үл итгэх үзлээр хандахыг аудитын ажлын явцад шаарддаг. Бид мөн:

- Нэгтгэсэн санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах зэрэг явдлуудыг агуулсан байдаг тул залилангаас үүсэх материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдааны улмаас үүсэх буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг.
- Группийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горимыг боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үндэслэл болон холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн бид олж авсан нотолгоондоо тулгуурлан Группийн тасралтгүй үйл ажиллагаагаа эрхлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл бид аудиторын тайланд нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл энэхүү тодруулга нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Бид дүгнэлтээ аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд үндэслэн гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь Группийг тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц болон агуулгыг тодруулгуудын хамт үнэлж, нэгтгэсэн санхүүгийн тайлан нь холбогдох ажил гүйлгээнүүд болон үйл явдлуудыг үнэн зөв илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.
- Группийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх зорилгоор Групп дэх компаниуд эсвэл бизнесийн нэгжүүдийн санхүүгийн мэдээллийн талаар аудитын хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авахын тулд групп аудитыг төлөвлөж, гүйцэтгэдэг. Бид групп аудитын зорилгоор гүйцэтгэсэн аудитын ажлыг чиглүүлэх, удирдах, хянах үүрэгтэй. Бид зөвхөн өөрсдийн аудитын дүгнэлтэнд хариуцлага хүлээнэ.



Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага, Үргэлжлэл

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн цар хүрээ, хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Мөн бид засаглах эрх бүхий этгээдүүдэд хараат бус байдлын талаарх холбогдох ёс зүйн шаардлагыг биелүүлсэн талаарх мэдэгдлийг хийдэг бөгөөд шаардлагатай үед бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц бүхий л харилцаа болон бусад асуудлууд, хараат бус байдлын эрсдэлийг бууруулсан эсвэл түүний эсрэг авсан хамгаалалтын хариу үйлдлүүдийн талаарх мэдэгдлийг хийдэг.

Засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас бид тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн өндөр ач холбогдолтой гэж үзсэн зүйлсийг аудитын гол онцлох зүйлс хэмээн тодотгосон болно. Бид аудитын гол онцлох зүйлсийг хууль тогтоомжоор нийтэд ил болгохыг хориглоогүй үед эсвэл маш ховор тохиолдолд тайланд тодруулахгүй байх нь тодруулснаас илүүтэйгээр олон нийтийн эрх ашигт нийцнэ гэж үзсэнээс уг онцлох зүйлсийг тайланд оруулахгүй хэмээн шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд эдгээр зүйлсийг тайландаа оруулдаг.

Энэхүү хараат бус аудиторын тайлангийн аудитын гэрээт ажлын партнер нь Ким Сон Минь, аудитын компанийн Гүйцэтгэх Захирал нь Г. Соёлмаа нар болно.



Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот

2026 оны 3 дугаар сарын 20-ны өдөр

Баталгаажуулсан:

Г. Соёлмаа
Гүйцэтгэх Захирал

Баталсан:

Ким Сон Минь
Партнер

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2026 оны 3 дугаар сарын 20-ны өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг нэгтгэсэн санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Тиймээс аудитын тайланг хэрэглэгчид нь уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүйг анхаарна уу. Энэхүү тайлан нь зөвхөн Группийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.

Хараат бус аудитын дүгнэлт, захидалтай “[Жилийн тайлан 2025](#)”-ын 103-107-р нүүр, Санхүүгийн тайлан болон тодруулгуудтай 108-172-р нүүрнээс танилцах боломжтой.


2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл																																																																																																																																																						
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/																																																																																																																																																						
	БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, СЕГМЕНТЭЭР /тэрбум төгрөг, %/ <table><thead><tr><th>Сегмент</th><th>Хувь (%)</th><th>Төрлөг (тэрбум төгрөг)</th></tr></thead><tbody><tr><td>Дотоод</td><td>81%</td><td>199.3</td></tr><tr><td>Гадаад</td><td>22.0</td><td>22.0</td></tr><tr><td>Экспорт</td><td>10%</td><td>24.9</td></tr><tr><td>Европ</td><td>12.5</td><td>12.5</td></tr><tr><td>Америк</td><td>6.9</td><td>6.9</td></tr><tr><td>Хятад</td><td>1.8</td><td>1.8</td></tr><tr><td>Их Британи</td><td>0.5</td><td>0.5</td></tr><tr><td>Солонгос</td><td>0.2</td><td>0.2</td></tr><tr><td>Нийт</td><td></td><td>246.2</td></tr></tbody></table> БОРЛУУЛАЛТ. ЦЭВЭР АШИГ /тэрбум төгрөг/ <table><thead><tr><th>Он</th><th>Дотоод</th><th>Гадаад</th><th>Экспорт</th><th>Нийт</th><th>Хувьчлал</th></tr></thead><tbody><tr><td>2007</td><td>20.3</td><td>0.7</td><td>(0.7)</td><td>20.3</td><td>20.3</td></tr><tr><td>2008</td><td>19.6</td><td>1.5</td><td></td><td>20.2</td><td>19.6</td></tr><tr><td>2009</td><td>28.9</td><td>3.4</td><td></td><td>32.3</td><td>28.9</td></tr><tr><td>2010</td><td>35.4</td><td>1.7</td><td></td><td>37.1</td><td>35.4</td></tr><tr><td>2011</td><td>40.8</td><td>5.3</td><td></td><td>46.1</td><td>40.8</td></tr><tr><td>2012</td><td>48.8</td><td>7.1</td><td></td><td>55.9</td><td>48.8</td></tr><tr><td>2013</td><td>65.9</td><td>10.5</td><td></td><td>76.4</td><td>65.9</td></tr><tr><td>2014</td><td>71.2</td><td>10.7</td><td></td><td>81.9</td><td>71.2</td></tr><tr><td>2015</td><td>88.7</td><td>16.1</td><td></td><td>104.8</td><td>88.7</td></tr><tr><td>2016</td><td>124.4</td><td>17.5</td><td></td><td>141.9</td><td>124.4</td></tr><tr><td>2017</td><td>173.4</td><td>17.8</td><td></td><td>191.2</td><td>173.4</td></tr><tr><td>2018</td><td>209.7</td><td>2.5</td><td></td><td>212.2</td><td>209.7</td></tr><tr><td>2019</td><td>117.1</td><td>144.3</td><td>7.0</td><td>268.4</td><td>117.1</td></tr><tr><td>2020</td><td>37.9</td><td>6.2</td><td></td><td>44.1</td><td>37.9</td></tr><tr><td>2021</td><td>6.8</td><td>3.7</td><td></td><td>10.5</td><td>6.8</td></tr><tr><td>2022</td><td>255.7</td><td>247.0</td><td>0.2</td><td>502.9</td><td>255.7</td></tr><tr><td>2023</td><td>246.2</td><td></td><td></td><td>246.2</td><td>246.2</td></tr><tr><td>2024</td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr><tr><td>2025</td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr></tbody></table>	Сегмент	Хувь (%)	Төрлөг (тэрбум төгрөг)	Дотоод	81%	199.3	Гадаад	22.0	22.0	Экспорт	10%	24.9	Европ	12.5	12.5	Америк	6.9	6.9	Хятад	1.8	1.8	Их Британи	0.5	0.5	Солонгос	0.2	0.2	Нийт		246.2	Он	Дотоод	Гадаад	Экспорт	Нийт	Хувьчлал	2007	20.3	0.7	(0.7)	20.3	20.3	2008	19.6	1.5		20.2	19.6	2009	28.9	3.4		32.3	28.9	2010	35.4	1.7		37.1	35.4	2011	40.8	5.3		46.1	40.8	2012	48.8	7.1		55.9	48.8	2013	65.9	10.5		76.4	65.9	2014	71.2	10.7		81.9	71.2	2015	88.7	16.1		104.8	88.7	2016	124.4	17.5		141.9	124.4	2017	173.4	17.8		191.2	173.4	2018	209.7	2.5		212.2	209.7	2019	117.1	144.3	7.0	268.4	117.1	2020	37.9	6.2		44.1	37.9	2021	6.8	3.7		10.5	6.8	2022	255.7	247.0	0.2	502.9	255.7	2023	246.2			246.2	246.2	2024						2025					
Сегмент	Хувь (%)	Төрлөг (тэрбум төгрөг)																																																																																																																																																					
Дотоод	81%	199.3																																																																																																																																																					
Гадаад	22.0	22.0																																																																																																																																																					
Экспорт	10%	24.9																																																																																																																																																					
Европ	12.5	12.5																																																																																																																																																					
Америк	6.9	6.9																																																																																																																																																					
Хятад	1.8	1.8																																																																																																																																																					
Их Британи	0.5	0.5																																																																																																																																																					
Солонгос	0.2	0.2																																																																																																																																																					
Нийт		246.2																																																																																																																																																					
Он	Дотоод	Гадаад	Экспорт	Нийт	Хувьчлал																																																																																																																																																		
2007	20.3	0.7	(0.7)	20.3	20.3																																																																																																																																																		
2008	19.6	1.5		20.2	19.6																																																																																																																																																		
2009	28.9	3.4		32.3	28.9																																																																																																																																																		
2010	35.4	1.7		37.1	35.4																																																																																																																																																		
2011	40.8	5.3		46.1	40.8																																																																																																																																																		
2012	48.8	7.1		55.9	48.8																																																																																																																																																		
2013	65.9	10.5		76.4	65.9																																																																																																																																																		
2014	71.2	10.7		81.9	71.2																																																																																																																																																		
2015	88.7	16.1		104.8	88.7																																																																																																																																																		
2016	124.4	17.5		141.9	124.4																																																																																																																																																		
2017	173.4	17.8		191.2	173.4																																																																																																																																																		
2018	209.7	2.5		212.2	209.7																																																																																																																																																		
2019	117.1	144.3	7.0	268.4	117.1																																																																																																																																																		
2020	37.9	6.2		44.1	37.9																																																																																																																																																		
2021	6.8	3.7		10.5	6.8																																																																																																																																																		
2022	255.7	247.0	0.2	502.9	255.7																																																																																																																																																		
2023	246.2			246.2	246.2																																																																																																																																																		
2024																																																																																																																																																							
2025																																																																																																																																																							

2025 ОНЫ САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ


ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	2024 он	2025 он	Өөрчлөлт	
				тоо	хувь
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	сая.төг	247,026	246,188	(839)	0%
Дотоод борлуулалт	сая.төг	163,359	199,275	35,916	22%
Экспортын борлуулалт	сая.төг	57,934	24,942	(32,993)	-57%
Гадаад борлуулалт	сая.төг	25,733	21,971	(3,762)	-15%
Борлуулсан бүтээгдэхүүний тоо ширхэг	мян.ширхэг	1,055	970	(85)	-8%
БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ	сая.төг	138,552	127,902	(10,650)	-8%
НИЙТ АШИГ	сая.төг	108,474	118,286	9,812	9%
Нийт ашгийн хувь	хувь	44%	48%	4%	9%
Үйл ажиллагааны зардал	сая.төг	81,395	59,800	(21,595)	-27%
Маркетингийн зардал	сая.төг	10,561	9,649	(912)	-9%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ	сая.төг	27,079	58,486	31,407	116%
Үйл ажиллагааны ашгийн хувь	хувь	11%	24%	13%	117%
Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	28,653	53,589	24,936	87%
Татварын өмнөх ашиг	сая.төг	(1,574)	4,897	6,471	411%
ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ	сая.төг	(3,657)	203	3,861	106%
Цэвэр ашгийн хувь	хувь	-1%	0%	2%	106%
Нийт үйл ажиллагааны зардал	сая.төг	219,947	187,702	(32,245)	-15%
ҮЙЛДВЭРЛЭЛ	мян.ширхэг	1,005	882	(123)	-12%
Сүлжмэл бүтээгдэхүүн	мян.ширхэг	653	566	(87)	-13%
Нэхмэл бүтээгдэхүүн	мян.ширхэг	323	286	(37)	-12%
Оёмол бүтээгдэхүүн	мян.ширхэг	29	31	1	4%
Пальто	мян.ширхэг	16	20	3	22%
Ээрмэл утас	тонн	191	211	20	10%
АЖИЛТНУУДЫН ТОО	хүн	1,652	1,193	(459)	-28%
Нэг ажилтанд ногдох орлого	мян.төг	149,532	206,360	56,828	38%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	сая.төг	20,354	2,222	(18,133)	-89%
НИЙТ ӨР ТӨЛБӨР	сая.төг	304,820	324,405	19,584	6%
Банкны зээл	сая.төг	228,136	278,048	49,911	22%
НИЙТ ХӨРӨНГӨ	сая.төг	306,277	302,249	(4,029)	-1%
Бараа материал	сая.төг	122,708	124,807	2,098	2%

2.2. Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО
/тэрбум төгрөг/




ЦЭВЭР АШИГ
/тэрбум төгрөг/




2025 онд компани 246.2 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, өмнөх оны түвшинг тогтвортой хадгалсан байна. Борлуулалтын орлогын бүтцийн хувьд сүлжмэл бүтээгдэхүүн 53%-ийг бүрдүүлж голлох жинг эзэлж байгаа бол нэхмэл бүтээгдэхүүн 19%, оёмол бүтээгдэхүүн 20%, бусад бүтээгдэхүүн 8%-ийг тус тус эзэлж байна. Бүтцийн өөрчлөлтөөс харахад сүлжмэл бүтээгдэхүүний эзлэх хувь буурч, бусад сегментүүдийн оролцоо харьцангуй нэмэгдсэн нь бүтээгдэхүүний багцын төрөлжилт сайжирч байгааг илтгэнэ. Мөн компани 2025 онд 0.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, 2024 оны 3.7 тэрбум төгрөгийн алдагдлаас ашигт ажиллагаанд шилжсэн. Энэ нь алдагдлыг 106%-аар бууруулж, үйл ажиллагааны үр ашиг болон зардлын хяналт мэдэгдэхүйц сайжирсныг харуулж байна.

АШГИЙН ҮЗҮҮЛЭЛТ




ӨР ТӨЛБӨРИЙН /EBITDA/




2025 онд компанийн ашигт ажиллагааны үзүүлэлтүүд 2024 онтой харьцуулахад мэдэгдэхүйц сайжирч, үйл ажиллагааны ашгийн хувь 2 пунктээр, EBITDA маржин 13 пунктээр, цэвэр ашгийн түвшин алдагдлаас ашигт шилжсэн нь үндсэн үйл ажиллагааны ашиг болон зардлын удирдлага сайжирч, эерэг өөрчлөлт гарч байгааг илтгэж байна. Өрийн удирдлага тогтвортой түвшинд хадгалагдаж, Өр/EBITDA харьцаа 5.9 болж сайжирсан нь санхүүгийн чадавх бэхжиж байгааг харуулж байна.

НИЙТ ХӨРӨНГӨ
/тэрбум төгрөг/




БАРАА МАТЕРИАЛЫН ЭРГЭЦ
/хоног/




2025 онд компанийн нийт хөрөнгө 302.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 1 хувиар буурсан нь хөрөнгийн хэмжээ тогтвортой байгааг илтгэж байна. Эздийн өмч -22.2 тэрбум төгрөгт хүрсэн нь хуримтлагдсан алдагдлын нөлөөлөл хэвээр байгааг харуулж байна. Гэсэн хэдий ч компанийн зүгээс эргэлтийн хөрөнгийн удирдлагыг сайжруулах, ялангуяа түүхий эд, бараа материалын нөөцийг бууруулах чиглэлд бодит арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд бараа материалын эргэлт 353 хоног болж, өмнөх оноос 1%-аар сайжирсан байна. Энэ нь хөрөнгийн ашиглалтыг нэмэгдүүлж, мөнгөн урсгалын үр ашгийг сайжруулах эерэг хандлагыг илэрхийлж байна.

ҮЙЛДВЭРЛЭСЭН ТОО
/мянган ширхэг/




БОРЛУУЛСАН ТОО
/мянган ширхэг/




2025 онд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо 12%, борлуулсан бүтээгдэхүүний тоо 8%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Харин бусад бүтээгдэхүүн буюу CashmereTech технологийн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийн борлуулалт 176%-аар буюу 24 мянган ширхгээр нэмэгдэн нийт борлуулалтад эзлэх жин нь 3 пунктээр нэмэгдсэн байна.

МАРКЕТИНГИЙН ЗАРДАЛ
/тэрбум төгрөг/



2025 оны нийт маркетингийн зардлыг өмнөх оноос 9% бууруулж 9.6 тэрбум төгрөгийг зарцуулсан. Үүнээс 82%-ийг буюу 7.9 тэрбум төгрөгийг гадаад зах зээл дэх маркетингийн зардал эзэлж байна. Тайлант онд гадаад зах зээлийг идэвхжүүлэх маркетингийн зардлыг өмнөх оноос 10%-аар бууруулсан. Мөн ROAS буюу 1 төгрөгийн дижитал маркетингийн зардлаас олж буй орлогын дүн 3.2 болж өмнөх оны мөн үеэс буурсан нь 2025 оноос брэндинг маркетингийг түлхүү хийн урамшууллын маркетингийг бууруулсантай холбоотой юм.

МӨНГӨН УРСГАЛ (ШУУД АРГААР)
/тэрбум төгрөг/




2025 онд үйл ажиллагаанаас нийт 268.6 тэрбум төгрөг орсон ба 2024 онтой харьцуулахад 2.6% өссөн. Харин гарах мөнгөн урсгалын хувьд нийт 251.1 тэрбум төгрөг зарцуулсан ба үүнээс 91.8 тэрбум төгрөгийг үйл ажиллагааны зардалд, 97.0 тэрбум төгрөгийг бэлтгэн нийлүүлэгчдийн төлбөрт, 35.8 тэрбум төгрөгийг татварын зардалд, санхүүжилтийн зардалд 25.9 тэрбум төгрөг тус тус төлсөн. Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ 3.1 тэрбум төгрөг байна.

2.3.

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл

ДОТООД ЗАХ ЗЭЭЛ



2025 онд дотоод зах зээл 199.3 тэрбум төгрөгийн борлуулалттай ажиллаж өмнөх оноос 22%-ийн өсөлт үзүүлсэн бөгөөд хамгийн өндөр борлуулалтыг хийсэн жил байв.




2025 онд дотоод зах зээлд 794 мянган ширхэг бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх онтой харьцуулахад 20%-ийн өсөлттэй байв.



Борлуулсан бүтээгдэхүүнийг нэр төрлөөр нь задалбал сүлжмэл бүтээгдэхүүн 58%, оёмол бүтээгдэхүүн 4%, нэхмэл бүтээгдэхүүн 32%, бусад бүтээгдэхүүн 6%-ийг тус тус эзэлж байна.


2025 онд дотоодын зах зээлд ноолууран гутлыг олон нэр төрлийн өргөн сонголттойгоор хэрэглэгчдэд хүргэснээс гадна, дулаан хадгалах чадвар өндөр, ус салхины хамгаалалттай, ус нэвтрүүлэхгүй, амьсгалах боломжтой зэрэг олон төрлийн онцлог шийдэлтэйгээр куртка, хантааз, савхин бээлий зэрэг шинэлэг CashmereTech бүтээгдэхүүнүүдийг худалдаанд нэвтрүүлж, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлснээр борлуулалтыг 156% өсгөсөн.

ДОТООД ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ



Говь ХК нь 2024 онд дотоод зах зээлийн 54%-ийг эзэлж байсан бол 2025 онд 66% болж 12%-ийн өсөлт үзүүлсэн.

БОРЛУУЛАЛТЫН БҮТЭЦ



Дотоод зах зээлийн борлуулалтын бүтцийг үнийн дүнгээр нь авч үзвэл жуулчдын борлуулалт 2024 онд 35% эзэлж байсан бол 2025 онд 7%-аар нэмэгдэж 42%-ийг эзэлж байна.

89% ↑
МОНГОЛ УЛСАД ИРСЭН
НИЙТ ЖУУЛЧИД
847 мянган хүн

43% ↑
ХУДАЛДАН АВАЛТ ХИЙСЭН
ЖУУЛЧДЫН САГСНЫ ДУНДАЖ
773 мянган төгрөг

32% ↑
ЖУУЛЧДЫН ХУДАЛДАН
АВАЛТЫН ДҮН
81.1 тэрбум төгрөг

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2025 онд Монгол улсад зочилсон нийт жуулчдын тоо өмнөх оноос 89% өсч 847 мянгад хүрсэн нь Монгол улсын хувьд түүхэн дээд үзүүлэлт байлаа. Монгол улсад зочилсон нийт жуулчдын 10 хүн тутмын нэг нь буюу 106 мянган жуулчин Говь брэндийн дэлгүүрээр үйлчлүүлсэн.


Улмаар жуулчдын худалдан авалтын дүн өмнөх оноос 32% өсч 81.1 тэрбум төгрөгт хүрсэн нь дотоодын нийт борлуулалтын өсөлт 22%-д хүрэхэд нөлөөлсөн бөгөөд гадаадаас Монгол улсад ирж буй жуулчдын тоо компанийн борлуулалтад шууд нөлөөлдөг гэдгийг харуулж байна.

Манай улс 2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарлаж байсан бөгөөд 2025 онд 1 сая жуулчин хүлээн авах зорилт дэвшүүлээд байснаас 847 мянган жуулчид ирсэн тул аялал жуулчлалын салбарын хөгжил, өсөлт нь Говь ХК төдийгүй дотоодын ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд борлуулалтаа өсгөхөд маш том түлхэц болсон.



Говь ХК-ийн хувьд энэхүү боломжийг ашиглан жуулчдыг татах, тав тухтай үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, бүтээгдэхүүний сонголтыг сайжруулж нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар стандартаа улам сайжруулахад жил бүр анхаарч ажиллаж байна. Үүнтэй холбоотойгоор 2025 оны 3-р сарын 1-нд Чингис Хаан олон улсын нисэх буудлын татваргүй бүсэд 125м2 талбайд салбар дэлгүүрээ нээж 23,274 гадаад дотоодын үйлчлүүлэгчдэд борлуулалт хийсэн.

ГАДААД ЗАХ ЗЭЭЛ



2025 онд гадаад зах зээлд нийт 46.9 тэрбум төгрөгийн борлуулалттай ажилласан ба энэ нь өмнөх оноос 44% буурсан үзүүлэлт байв.

ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН БОРЛУУЛАЛТЫН БҮТЭЦ



Гадаад зах зээлийг бүтцээр нь аваад үзвэл 53%-ийг экспортын буюу бөөний борлуулалт, 47%-ийг гадаад дахь охин компаниудын борлуулалт буюу онлайн болон биет дэлгүүрийн борлуулалт эзэлж байна.

ЭКСПОРТЫН БОРЛУУЛАЛТ



2025 онд экспортын зах зээлд 27 харилцагчид бүтээгдэхүүнээ нийлүүлж, 24.9 тэрбум төгрөгийн борлуулалттай ажилласан нь


өмнөх оноос 57% буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь компанийн бодлогын хүрээнд үйлдвэрийн бүтээмж болон ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор экспортын харилцагчдын тоог бууруулах шийдвэр гаргасантай холбоотой. Тодруулбал, 2024 онтой харьцуулахад харилцагчдын тоог 46%-аар бууруулж, илүү цөөн боловч тогтвортой, стратегийн ач холбогдолтой харилцагчдад бүтээгдэхүүн нийлүүлэх бодлого баримталж ажилласан. Үүний үр дүнд нийлүүлэлтийн бүтэц өөрчлөгдөж, экспортын борлуулалтын нийт дүн өмнөх онтой харьцуулахад буурсан үзүүлэлттэй гарсан болно.

2025 оны 11-р сард Казакстан улсын Алмата хотын олон улсын нисэх онгоцны буудалд Франчайз дэлгүүр шинээр нээн 2025 оны сүүлийн байдлаар 3 улсын 4 хотод 5 франчайз дэлгүүртэй үйл ажиллагаа явуулж байна.

Франчайз дэлгүүрийн байршил:

1. Япон улс, Токио хот
2. Турк улс, Анкар хот
3. Турк улс, Истанбул хот
4. Турк улс, Истанбул хот
5. Казахстан улс, Алматы хот

ГАДААД БОРЛУУЛАЛТ



2025 онд гадаад борлуулалт 22.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байсан нь өмнөх оноос 15% буурсан үзүүлэлт байв. Үүний гол шалтгаан нь бүтээгдэхүүний үндсэн үнийг нэмэгдүүлж, хямдралын хувийг бууруулсан бодлоготой

холбоотой. Тус бодлого нь брэндийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, зах зээлд илүү өндөр үнэлэмжтэй брэндийн байр суурийг бүрдүүлэх зорилготой хэрэгжсэн бөгөөд үүний зэрэгцээ компанийн алдагдлыг бууруулах, ашигт ажиллагааг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ учир борлуулалтын хэмжээ тодорхой хэмжээгээр буурсан хэдий ч урт хугацаанд брэндийн үнэ цэнэ болон санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн стратегийн шийдвэр юм.

Гадаад борлуулалтын зах зээлээ тэлэх зорилгоор 2025 оны 8-р сард БНСУ-д охин компаниа байгуулав. Мөн борлуулалтын суваг хөгжүүлэх ажлын хүрээнд борлуулалтын оргил үеүдэд АНУ-ын зах зээлд Macy's, Amazon гэсэн хоёр шинэ сувагтай хамтран ажиллаж эхэлсэн нь 2025 оны нийт борлуулалтын үр дүнд эерэг нөлөө үзүүлсэн.


ПРОГРАММ ХӨГЖҮҮЛЭЛТ, ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ

Говь ХК нь сүүлийн жилүүдэд компанийн хэмжээнд Product Lifecycle Management (PLM), SAP S/4 HANA Enterprise Resource Management (ERP), INA Manufacturing Execution System (MES), Conveyor Belt (дамжлагын систем) зэрэг томоохон системүүдийг шат дараатай нэвтрүүлэн, үйлдвэрлэл болон үйл ажиллагааны бүхий л түвшинд программ хөгжүүлэлт, дижитал шилжилтийн ажилд томоохон хөрөнгө оруулалтыг хийсэн.


НЭВТРҮҮЛСЭН СИСТЕМҮҮД



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ — СИСТЕМ ТУС БҮР



ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН ҮР ДҮН




Системүүдийг нэвтрүүлснээр үйл ажиллагааны үр ашиг дунджаар 33% сайжирч, цахим шилжилт амжилттай явагдаж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛСЭН ШИНЭ ТЕХНОЛОГИ, БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

CashmereTech

ИННОВАЦ ШИНГЭСЭН, НООЛУУРЫН ХОЛЬЦТОЙ ШИНЭ НЭР
ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН



2023 оноос CashmereTech Footwear буюу ноолууран гутлыг зах зээлд нэвтрүүлж, 2024–2025 онуудад үргэлжлүүлэн хөгжүүлсэн. Мөн шинэ нэр төрөл болох CashmereTech Outerwear буюу -15-аас -30 градус хүртэл өмсөх боломжтой олон загварын курткыг зах зээлд шинээр нэвтрүүлж хэрэглэгчдэд хүргэсэн. Цаашид CashmereTech-ийн хүрээнд жилийн бүх улиралд өмсөх боломжтой нэмэлт шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнийг шат дараатай хөгжүүлэхээр төлөвлөж байна.

CashmereTech Outerwear 2025

Ноолуурын холиотой дүүргэлттэй шинэ нэр төрлийн куртка

Монголын эрс тэс хуурай цаг агаар болон өдөр тутмын амьдралын хэрэглээнд тохирсон ноолууран дүүргэлтийг бүтээх зорилгоор Полистер, Ноос болон Ноолуурын холиотой куртканы дүүргэлт зохион бүтээв.




Ноолуурын хольцтой инновац шингэсэн шинэ төрлийн дүүргэлттэй 8 шинэ загварын куртка зохион бүтээж, зах зээлд гаргасан.

Өдөн дүүргэлттэй, нэг тал нь 100% ноолуурын утастай сүлжмэл, нөгөө тал нь 100% нейлон ус нэвтрүүлэхгүй, амьсгалдаг даавуутай, хоёр талдаа өмсөх боломжтой шинэ нэр төрлийн 2 шинэ загварын хантааз зохион бүтээж, зах зээлд гаргасан.

CashmereTech Footwear 2025 Ноолуурын хольцтой шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн

Ноолуурын хольцтой инновац шингэсэн 11 шинэ загварын гутал зохион бүтээж, зах зээлд гаргасан.



ЗАГВАР, ДИЗАЙНЫ САЙЖРУУЛАЛТ

Тогтвортой үйлдвэрлэлийг дэмжсэн залгаа оёдолгүй 3D загварын хөгжүүлэлт



Говь ХК нь тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор технологийн шинэчлэл болон бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг тасралтгүй хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үүний хүрээнд дотоод болон гадаад зах зээлд өндөр эрэлттэй үндсэн загваруудыг улам боловсронгуй болгож, өмнө нь 2D буюу хавтгай сүлжмэлийн технологиор оёдолтой үйлдвэрлэж байсан загваруудыг 3D буюу залгаа оёдолгүй сүлжих технологид шилжүүлэн хөгжүүлж хэрэглэгчдэд хүрэх бүтээгдэхүүний чанар, үнэ цэнийг улам нэмэгдүүлэхийг зорьж байна.

Энэхүү технологийн шинэчлэл нь бүтээгдэхүүн нь өмсгөлийн хувьд оёдол мэдрэгдэхгүй тав тухтайгаас гадна үйлдвэрлэлийн оёдлын шат дамжлагыг багасган, өртөг зардлыг бууруулахын зэрэгцээ материалын хаягдлыг багасган, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг дэмжихэд чухал хувь нэмэр оруулж байна.

Үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээлэлтэй “[Жилийн тайлан 2025](#)” -ын 30-39-р нүүрнээс танилцах боломжтой.

2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүүгийн байдлын гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.																																																																																																																																																									
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;																																																																																																																																																										
	САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ <table><tr><th rowspan="2">Санхүүжүүлэгчийн нэр</th><th rowspan="2">Валют</th><th rowspan="2">Дуусах хугацаа</th><th colspan="2">2024.12.31</th><th colspan="2">2025.12.31</th></tr><tr><th>мян.валют</th><th>мян.төг</th><th>мян.валют</th><th>мян.төг</th></tr><tr><td colspan="7">Банкны зээл</td></tr><tr><td>Голомт банк (Урт хугацаат зээл)</td><td>MNT</td><td>2025</td><td>-</td><td>3,333,333</td><td>-</td><td>-</td></tr><tr><td>Голомт банк (Урт хугацаат зээл)</td><td>MNT</td><td>2027</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>46,400,000</td></tr><tr><td>Голомт банк (Зээлийн шугам)</td><td>MNT</td><td>2028</td><td>-</td><td>9,300,000</td><td>-</td><td>5,065,000</td></tr><tr><td>Голомт банк (Богино хугацаат зээл)</td><td>MNT</td><td>2025</td><td>-</td><td>10,400,000</td><td>-</td><td>-</td></tr><tr><td>Хаан банк (Зээлийн шугам)</td><td>MNT</td><td>2027</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>100</td></tr><tr><td>Хаан банк (Урт хугацаат зээл)</td><td>MNT</td><td>2027</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>5,666,660</td></tr><tr><td>Хас банк (Зээлийн шугам)</td><td>MNT</td><td>2029</td><td>-</td><td>36,210,000</td><td>-</td><td>40,000,000</td></tr><tr><td>Хас банк (Урт хугацаат зээл)</td><td>MNT</td><td>2027</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>10,666,667</td></tr><tr><td>Хас банк (Богино хугацаат зээл)</td><td>MNT</td><td>2025</td><td>-</td><td>8,333,333</td><td>-</td><td>-</td></tr><tr><td>Азийн хөгжлийн банк (ADB)</td><td>USD</td><td>2026</td><td>\$ 9,600</td><td>32,834,400</td><td>\$ 4,800</td><td>17,071,968</td></tr><tr><td>Азийн хөгжлийн банк (ADB)</td><td>USD</td><td>2026</td><td>\$ 14,400</td><td>49,251,600</td><td>\$ 7,200</td><td>25,607,952</td></tr><tr><td>Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк (IIB)</td><td>EUR</td><td>2027</td><td>€ 14,000</td><td>49,937,720</td><td>€ 14,000</td><td>58,614,080</td></tr><tr><td>Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк (IIB)</td><td>EUR</td><td>2027</td><td>€ 8,000</td><td>28,535,840</td><td>€ 8,000</td><td>33,493,760</td></tr><tr><td>EBRD</td><td>MNT</td><td>2028</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>35,461,400</td></tr><tr><td>Нийт /Банкны зээл/</td><td></td><td></td><td></td><td>228,136,227</td><td></td><td>278,047,587</td></tr><tr><td colspan="7">Бондын санхүүжилт</td></tr><tr><td>Бонд (Богино хугацаат зээл) *</td><td>USD</td><td>2025</td><td>\$ 3,250</td><td>11,115,813</td><td>-</td><td>-</td></tr><tr><td>Нийт санхүүжилт</td><td></td><td></td><td></td><td>239,252,039</td><td></td><td>278,047,587</td></tr></table> Монгол банкны ханш /төг/<table><tr><td></td><td>2024.12.31</td><td>2025.12.31</td></tr><tr><td>USD</td><td>3,420.25</td><td>3,556.66</td></tr><tr><td>EUR</td><td>3,566.98</td><td>4,186.72</td></tr></table>		Санхүүжүүлэгчийн нэр	Валют	Дуусах хугацаа	2024.12.31		2025.12.31		мян.валют	мян.төг	мян.валют	мян.төг	Банкны зээл							Голомт банк (Урт хугацаат зээл)	MNT	2025	-	3,333,333	-	-	Голомт банк (Урт хугацаат зээл)	MNT	2027	-	-	-	46,400,000	Голомт банк (Зээлийн шугам)	MNT	2028	-	9,300,000	-	5,065,000	Голомт банк (Богино хугацаат зээл)	MNT	2025	-	10,400,000	-	-	Хаан банк (Зээлийн шугам)	MNT	2027	-	-	-	100	Хаан банк (Урт хугацаат зээл)	MNT	2027	-	-	-	5,666,660	Хас банк (Зээлийн шугам)	MNT	2029	-	36,210,000	-	40,000,000	Хас банк (Урт хугацаат зээл)	MNT	2027	-	-	-	10,666,667	Хас банк (Богино хугацаат зээл)	MNT	2025	-	8,333,333	-	-	Азийн хөгжлийн банк (ADB)	USD	2026	\$ 9,600	32,834,400	\$ 4,800	17,071,968	Азийн хөгжлийн банк (ADB)	USD	2026	\$ 14,400	49,251,600	\$ 7,200	25,607,952	Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк (IIB)	EUR	2027	€ 14,000	49,937,720	€ 14,000	58,614,080	Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк (IIB)	EUR	2027	€ 8,000	28,535,840	€ 8,000	33,493,760	EBRD	MNT	2028	-	-	-	35,461,400	Нийт /Банкны зээл/				228,136,227		278,047,587	Бондын санхүүжилт							Бонд (Богино хугацаат зээл) *	USD	2025	\$ 3,250	11,115,813	-	-	Нийт санхүүжилт				239,252,039		278,047,587		2024.12.31	2025.12.31	USD	3,420.25	3,556.66	EUR	3,566.98	4,186.72
Санхүүжүүлэгчийн нэр	Валют	Дуусах хугацаа				2024.12.31		2025.12.31																																																																																																																																																			
			мян.валют	мян.төг	мян.валют	мян.төг																																																																																																																																																					
Банкны зээл																																																																																																																																																											
Голомт банк (Урт хугацаат зээл)	MNT	2025	-	3,333,333	-	-																																																																																																																																																					
Голомт банк (Урт хугацаат зээл)	MNT	2027	-	-	-	46,400,000																																																																																																																																																					
Голомт банк (Зээлийн шугам)	MNT	2028	-	9,300,000	-	5,065,000																																																																																																																																																					
Голомт банк (Богино хугацаат зээл)	MNT	2025	-	10,400,000	-	-																																																																																																																																																					
Хаан банк (Зээлийн шугам)	MNT	2027	-	-	-	100																																																																																																																																																					
Хаан банк (Урт хугацаат зээл)	MNT	2027	-	-	-	5,666,660																																																																																																																																																					
Хас банк (Зээлийн шугам)	MNT	2029	-	36,210,000	-	40,000,000																																																																																																																																																					
Хас банк (Урт хугацаат зээл)	MNT	2027	-	-	-	10,666,667																																																																																																																																																					
Хас банк (Богино хугацаат зээл)	MNT	2025	-	8,333,333	-	-																																																																																																																																																					
Азийн хөгжлийн банк (ADB)	USD	2026	\$ 9,600	32,834,400	\$ 4,800	17,071,968																																																																																																																																																					
Азийн хөгжлийн банк (ADB)	USD	2026	\$ 14,400	49,251,600	\$ 7,200	25,607,952																																																																																																																																																					
Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк (IIB)	EUR	2027	€ 14,000	49,937,720	€ 14,000	58,614,080																																																																																																																																																					
Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк (IIB)	EUR	2027	€ 8,000	28,535,840	€ 8,000	33,493,760																																																																																																																																																					
EBRD	MNT	2028	-	-	-	35,461,400																																																																																																																																																					
Нийт /Банкны зээл/				228,136,227		278,047,587																																																																																																																																																					
Бондын санхүүжилт																																																																																																																																																											
Бонд (Богино хугацаат зээл) *	USD	2025	\$ 3,250	11,115,813	-	-																																																																																																																																																					
Нийт санхүүжилт				239,252,039		278,047,587																																																																																																																																																					
	2024.12.31	2025.12.31																																																																																																																																																									
USD	3,420.25	3,556.66																																																																																																																																																									
EUR	3,566.98	4,186.72																																																																																																																																																									
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/																																																																																																																																																										

ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгээгүй.

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

Сонирхлын зөрчилтэй болон холбоотой талуудтай хийх хэлцэлд зөвшөөрөл олгох, хяналт тавих процесс

Говь ХК-ийн “Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам”-ын дагуу жил бүрийн эхэнд Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа, үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдах хэлцэл хийхийг зөвшөөрсөн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн жагсаалт, хэлцлийн төсвийг ТУЗ-ийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар баталдаг.

Дээрх журмын дагуу батлагдсан жагсаалтад ороогүй этгээдтэй хийх болон батлагдсан төсвөөс хэтэрсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийх бүрд тухайлсан тогтоолоор ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн зөвшөөрөл олгодог.

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо нь Компанийн хэмжээнд хийгдэж буй сонирхлын зөрчилтэй хэлцэл нь батлагдсан төсвийн хүрээнд, зах зээлийн үнэ нөхцөлөөр, хуулийн дагуу хийгдэж байгаа эсэх дээр улирал бүрийн хорооны хурлаараа дамжуулан тогтмол хяналт тавьж ажилладаг.

2025 оны сонирхлын зөрчилтэй хэлцэл: ТУЗ-ийн 2025 оны 03-р сарын 20-ны №07 тоот тогтоолоор тус зөвшөөрлийг олгосон бөгөөд Эрсдэл, аудитын хорооны ээлжит хурлууд дээр гүйцэтгэлтэй танилцан хяналт тавихаас гадна ТУЗ-ийн жилийн эцсийн хурал дээр 2025 оны нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн гүйцэтгэлтэй танилцаж хяналтыг хэрэгжүүлсэн.

Огноо	Гэрээ хэлцлийн утга	Үнийн дүн	Гэрээний нөгөө тал	Гэрээний нөхцөл, болзол	Эхлэх огноо	Дуусах огноо	Хэлцэл баталсан
2025.03.20	2025 онд сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хийгдэх хэлцэлд зөвшөөрөл олгох	-	Таван Богд Группийн охин компаниуд	Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа, үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдах, зээлийн шугамын гэрээ байгуулах	2025.01.01	2025.12.31	№07
2025.04.02	Хаан банкны зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	Зээлийн эрхийн хэмжээг 14 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх	Хаан Банк ХК	Таван Богд Холдингс ХХК болон түүний охин компаниудтай хамтарсан зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	2024.12.31	2027.12.31	№13
2025.04.09	Хэвлэх үйлчилгээ авах	11.8 сая төгрөг	Улаанбаатар Принт ХХК	Хэвлэх үйлчилгээ авах	2025.03.01	2025.03.31	№15
2025.04.17	Хаан банкны зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	-	Хаан Банк ХК	Таван Богд Холдингс ХХК болон түүний охин компаниудтай хамтарсан зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	2024.12.31	2027.12.31	№18
2025.05.14	Эргэлтийн хөрөнгийн ногоон зээлийн гэрээ байгуулах тухай	6 тэрбум төгрөг	Хаан Банк ХК	Ноос, ноолуур, арьс ширний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгийн ногоон зээл авах	2025.05.14	2027.05.14	№21
2025.06.19	Андеррайтерийн үйлчилгээний гэрээ байгуулах*	400 сая төгрөг	Таван Богд Капитал ҮЦК ХХК	Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх*	2025.06.20	2025.06.30	№27
2025.07.04	Үнэт цаас худалдан авах	32 тэрбум төгрөг	Бета Лизинг ХХК	Үнэт цаас /өрийн хэрэгсэл/ худалдан авах	2025.07.18	2026.02.28	№29
2025.09.09	Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх	-	Таван Богд Холдингс ХХК	Шаардах эрх хэрэгжүүлсэн хувьцааг тогтоолд заасан үнэ, журмын дагуу худалдан авах	2025.09.11	2025.10.23	№39
2025.09.09	Брокерын үйлчилгээ үзүүлэх үнэт цаасны компанийг сонгох	-	Таван Богд Капитал ҮЦК ХХК	Брокерын үйлчилгээ үзүүлэх	2025.09.11	2025.10.23	№40
2025.10.20	Хаан банкны зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	Зээлийн эрхийн хэмжээг 13 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх	Хаан Банк ХК	Таван Богд Холдингс ХХК болон түүний охин компаниудтай хамтарсан зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	2024.12.31	2027.12.31	№48
2025.11.06	Үнэт цаас худалдахыг зөвшөөрөх	19 тэрбум төгрөг	Таван Богд Тек ХХК / хуучнаар Бета Лизинг ХХК/	Үнэт цаас /өрийн хэрэгсэл/-ийг хугацаанаас нь өмнө эргүүлэн худалдах	2025.11.11	2025.11.11	№49
2025.11.11	Санхүүжилт хийхийг зөвшөөрөх	10 тэрбум төгрөг	Тваан Богд Нура ХХК	Санхүүжилт хийх	2025.11.11	2027.11.11	№50

*Говь ХК нь 2025 оны 6-р сард биржийн бус зах зээлд өрийн хэрэгсэл (бонд) гаргах бэлтгэл ажлын хүрээнд Таван Богд Капитал ҮЦК ХХК-тай андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан ч, тус өрийн хэрэгслийг гаргаагүй тул зөвхөн бондын танилцуулга баримт бичиг боловсруулсан үйлчилгээний хөлс (20 сая төгрөг)-ийг төлсөн.

4.

Цалин урамшууллын мэдээлэл

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооноос тодорхойлон санал боловсруулж Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэдэг. Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин сар бүр олгох тогтмол цалин болон хурлын оролцоонд үндэслэсэн цалин гэсэн бүтэцтэй байдаг. 2024 оны 4-р сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг дараах байдлаар тогтоосон. 2025 онд цалингийн хэмжээнд өөрчлөлт ороогүй.

ТОГТМОЛ ЦАЛИН

Ердийн гишүүний үндсэн цалин

1,400,000₮

Хараат бус гишүүний үндсэн цалин

2,800,000₮

ТУЗ-ийн даргын албан тушаалын нэмэгдэл

1,000,000₮

ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга нарын албан тушаалын нэмэгдэл

400,000₮

ОРОЛЦООНД ҮНДЭСЛЭСЭН НЭМЭЛТ ЦАЛИН

ТУЗ-ийн хурал,
Хувьцаа эзэмшигчдийн хурал,
ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцсон оролцоо тутамд

650,000₮

ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ЗАРЧИМ

Цалин, урамшууллын хорооны 2024 оны эхний хурлаар ТУЗ-ийн гишүүдийн цалин, хангамж, урамшууллын зарчмыг дараах байдлаар тодорхойлсон.

ТУЗ-ийн гишүүд нь компанийн санхүү, үр дүнгээс хамаарсан аливаа урамшуулал авахгүй.

ТУЗ-ийн хараат бус гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хариуцлагыг үнэлэх зорилгоор хараат бус гишүүдийн үндсэн цалинг ердийн гишүүдийнхээс өндөр байлгана.

Компанийн Менежмент багт ажилладаг ТУЗ-ийн ердийн гишүүд нь ТУЗ-ийн гишүүний хувьд аливаа хангамжийг давхар авахгүй.

2025 ОНЫ ЦАЛИН

ТУЗ-ийн цалин урамшуулал	2024 он Гүйцэтгэл	2025 он		Өөрчлөлт %	
		Төсөв*	Гүйцэтгэл	2024Г/2025Г	2025Т/2025Г
Тогтмол цалин	213,533	237,200	233,600	9%	-2%
Оролцооны цалин	44,200	59,150	31,850	-28%	-46%
НДШ	27,371	32,598	26,461	-3%	-19%
Дүн	285,104	328,948	291,911	2%	-11%

*2025 оны 4-р сарын 25-ны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн 2025 оны цалингийн төсвийг баталсан.

МЕНЕЖМЕНТ БАГИЙН ЗАХИРЛУУДЫН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

Гүйцэтгэх захирлын цалин, урамшуулал

Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлдэг. Гүйцэтгэх захирлын цалин, урамшуулал нь компанийн санхүү, үйл ажиллагааны үр дүн болон ажлын гүйцэтгэл, ур чадварын үнэлгээтэй уялдсан байх бөгөөд цалин, урамшууллын хэмжээ, түүнийг олгох зарчмыг ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо тогтоодог.

Гүйцэтгэх захирлын эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон Менежментийн гэрээний нөхцөлийг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо боловсруулан, гэрээний агуулгыг ТУЗ-ийн хурлаар баталдаг бөгөөд ТУЗ-өөс 2024 оны 3-р сард шинээр томилогдсон Гүйцэтгэх захиралтай Менежментийн гэрээг байгуулсан.

Менежмент багийн бусад захирлуудын цалин, урамшуулал

Гүйцэтгэх захирлаас бусад Менежмент багийн захирлуудын цалин, урамшуулал, түүнийг олгох шалгуур үзүүлэлтийг Цалин, урамшууллын бодлогын хүрээнд нь Гүйцэтгэх захирал тогтоодог. Харин ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалинг ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны саналыг үндэслэн ТУЗ тогтоодог.

Менежмент багийн захирлууд нь ТУЗ-ийн гишүүний үүргийг давхар гүйцэтгэж байгаа тохиолдолд ТУЗ-ийн гишүүний цалинг авах ба хангамж, урамшууллыг давхар авахгүй байх зарчмыг Цалин урамшууллын хороо тогтоосон.

ЦАЛИНГИЙН БҮТЭЦ

Үзүүлэлт	Эзлэх жин
Үндсэн цалин	Албан тушаалын чиг үүргээс хамаарна.
Гүйцэтгэлээс хамаарсан нэмэгдэл цалин /KPI/ - Компанийн борлуулалт, ашгаас хамаарсан үзүүлэлт - Тухайн ажилтны төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлийн үзүүлэлт - Хариуцсан газар нэгжийн хүний нөөцийн эргэцийн үзүүлэлт	

Урамшууллын зарчим

Говь ХК-д мөрдөгдөж буй Цалин урамшууллын бодлого, Үр дүнгийн урамшуулал олгох журмын дагуу компанийн санхүү үрдүнгийн гүйцэтгэлээс хамааран тухайн жилийн бизнес төлөвлөгөөний борлуулалтын гүйцэтгэл, цэвэр ашгийн гүйцэтгэлийн тодорхой шалгуурыг хангасан үед урамшууллыг олгодог.

2025 ОНЫ ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

/мянган төгрөг/


Менежмент багийн цалин, урамшуулал	2024 он	2025 он	Өөрчлөлт %
Цалин	2,079,731	1,254,971	-40%
Урамшуулал	114,214	57,955	-49%
НДШ	274,787	161,841	-41%
Дүн	2,468,732	1,474,766	-40%

5. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Говь ХК-ийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид, удирдлагууд болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж, компанийн зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянахад чиглэсэн бүтэц, зохицуулалтын нийлбэр юм.

Бид олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хувьд Компанийн тухай хууль, Монголын компанийн засаглалын кодекс, олон улсын сайн засаглалын туршлагаас суралцан засаглалын тогтолцоогоо тасралтгүй сайжруулан, холбогдох хууль дүрэм журмуудын хэрэгжилтийг ханган, улсдаа компанийн засаглалаар тэргүүлсэн үлгэр жишээ компани болохыг зорин ажилладаг.



Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийг томилдог бөгөөд ТУЗ нь хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдынхаа эрх ашгийг хангах, хөрөнгийн өгөөжүр ашгийг нэмэгдүүлэх, компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавин, оновчтой чиглүүлгээр ханган ажиллахыг зорьдог.

ТУЗ-ийн дэргэд Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Эрсдэл аудитын хороо гэсэн 3 хороо үйл ажиллагаа явуулан тус бүрийн чиг үүргийнхээ дагуу бодлогыг хэрэгжүүлэн компанийн Менежмент багийнхны үйл ажиллагаанд хяналт тавин дүгнэлт өгч, үр дүнгээ ТУЗ-д тайлагнан ажилладаг.

Эрсдэл аудитын хорооны харьяанд Дотоод аудитын нэгжийг ажиллуулан компанийн хэмжээнд хараат бусаар дотоод хяналтыг хэрэгжүүлдэг.

ТУЗ-ийн харьяанд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга ажилладаг ба ТУЗ-ийн үйл ажиллагаа болон компанийн засаглалын дотоод зохион байгуулалтыг хариуцдаг.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд удирдлага юм.

2025 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРАЛ

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 4-р сарын 25-ны өдрийн 14:00 цагт ХААН театрт амжилттай зохион байгуулагдав.

Хурлын ирц

Хуралд урьдчилан санал өгөх арга хэлбэрээр нийт 13,341,856 ширхэг хувьцааны 1.71 хувийн саналын эрхтэй 563 хувьцаа эзэмшигч, хурлын өдөр биечлэн оролцох арга хэлбэрээр 681,455,412 ширхэг хувьцааны 87.35 хувийн саналын эрхтэй 99 хувьцаа эзэмшигч буюу нийт 694,797,268 ширхэг хувьцааны саналын эрхтэй 662 хувьцаа эзэмшигч оролцсоноор хурлын ирц 89.06% болж бүрдэн хурал хүчин төгөлдөр явагдав.

Хурлаар танилцуулсан асуудал

1. Говь ХК-ийн 2024 оны санхүү үр дүн болон үйл ажиллагааны тайлан;
2. 2024 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараахгүй тухай ТУЗ-ийн тогтоол;
3. ТУЗ-өөс компанийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаар гаргасан дүгнэлт;
4. Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл;
5. ТУЗ-ийн 2024 оны ажлын тайлан, 2025 оны цалингийн төсөв;
6. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга.

Хурлаас гарсан шийдвэр

Хувьцаа эзэмшигчид дээрх асуудлуудтай холбогдох тайлан илтгэлүүдийг сонсож, асуулт хариулт болон санал хүсэлтээ хэлэлцсэний эцэст саналын хуудсаар саналаа өгсөн бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараах шийдвэрийг гаргав.

1. ТУЗ-өөс компанийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг 99.99%-ийн саналаар батлав.
2. Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг 99.99%-ийн саналаар батлав.
3. ТУЗ-ийн 2025 оны цалингийн төсвийг 99.99%-ийн саналаар батлав.
4. ТУЗ-ийн гишүүдийг 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаатай сонгон томилов.

2025 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2025 оны 9-р сарын 8-ны өдрийн 14:00 цагт Говь ХК-ийн байр, Сургалтын танхимд амжилттай зохион байгуулагдав.

Хурлын ирц

Хуралд урьдчилан санал өгөх арга хэлбэрээр нийт 14,866,699 ширхэг хувьцааны 1.91 хувийн саналын эрхтэй 475 хувьцаа эзэмшигч, хурлын өдөр биечлэн оролцох арга хэлбэрээр 682,231,660 ширхэг хувьцааны 87.45 хувийн саналын эрхтэй 31 хувьцаа эзэмшигч буюу нийт 697,098,359 ширхэг хувьцааны саналын эрхтэй 506 хувьцаа эзэмшигч оролцсоноор хурлын ирц 89.36% болж бүрдэн хурал хүчин төгөлдөр явагдав.

Хурлаар танилцуулсан асуудал

1. Компанийн хэлбэрийг өөрчлөх;
2. Компанийн дүрмийг шинээр батлах.

Хурлаас гарсан шийдвэр

Хувьцаа эзэмшигчид дээрх асуудлуудтай холбогдох илтгэлүүдийг сонсож, асуулт хариулт болон санал хүсэлтээ хэлэлцсэний эцэст саналын хуудсаар саналаа өгсөн бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас дараах шийдвэрийг гаргав.

1. Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) болгох замаар Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай асуудлыг 99.99%-ийн саналаар батлав.
2. Компанийн хэлбэр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Говь ХХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг 99.99%-ийн саналаар батлав.

Уг шийдвэр нь холбогдох хууль, зохицуулалтын шаардлагын дагуу эрх бүхий байгууллагын дүгнэлт, зөвшөөрлийн шатанд үргэлжлэн хэрэгжиж байна.

ТУЗ-ИЙН 2025 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Хурал	Ээлжит хурал	Ээлжит бус хурал	Цахим санал хураалт	Хэлэлцсэн асуудал	Шийдвэр	Санал зөвлөмж	Үүрэг даалгавар	Баталсан тогтоол
ТУЗ-ийн хурал	2	3	21	57	62	6	4	53
Хараат бус гишүүдийн хурал	1	-	-	7	5	-	-	-
Эрсдэл, аудитын хорооны хурал	3	-	3	24	11	12	8	4
Нэр дэвшүүлэх хорооны хурал	1	2	4	15	14	4	12	8
Цалин, урамшууллын хорооны хурал	1	-	-	6	7	2	1	1
Нийт	8	5	28	109	99	24	25	66

Говь ХК-ийн ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороод нь 2025 онд нийт 8 ээлжит хурал, 5 ээлжит бус хурал, 28 цахим санал хураалт зохион байгуулж гишүүд идэвх санаачилгатай ажиллан нийт 109 асуудлыг хэлэлцэн, 99 шийдвэр гаргаж, 66 тогтоол баталсан бөгөөд чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 24 санал зөвлөмж, 25 үүрэг даалгавруудыг өгч, хэрэгжилт дээр нь хяналт тавьж анхаарч ажиллав. ТУЗ-ийн шийдвэрийн биелэлт 97%, удирдлагуудад өгсөн үүрэг даалгаврын биелэлт 83% хэрэгжилттэй байв.

2025 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Говь ХК-ийн ТУЗ нь 2025 онд 2 ээлжит хурал, 3 ээлжит бус хурал, 21 удаагийн цахим санал хураалт зохион байгуулж, нийт 57 асуудал хэлэлцэж, 62 шийдвэр гаргав. Мөн чиг үүргийнхээ хүрээнд 6 төрлийн санал зөвлөмж, 4 үүрэг даалгаврыг холбогдох албан тушаалтнуудад өгч, хяналт тавьж ажилласан бөгөөд 53 тогтоол батлав. Тайлант хугацаанд ТУЗ-ийн шийдвэрийн биелэлт 99%, удирдлагуудад өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт 100% байв.

2025 онд ТУЗ-ийн зүгээс компанийн санхүү, үйл ажиллагаанд хяналт тавих, стратегийн чиглэл өгөх үндсэн чиг үүргийнхээ хүрээнд тогтмол, системтэй ажиллав. Оны эхний хурлаар компанийн бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, цаашид сар бүр санхүү, үр дүнгийн тайлангаар дамжуулан төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавин, шаардлагатай зөвлөмж, чиглэлийг удирдлагын багт өгч ажилласан.

Компанийн засаглалыг сайжруулах, дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэх зорилтын хүрээнд 3-р сард Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталж, хууль тогтоомж болон олон улсын шилдэг туршлагад нийцүүлэн хэрэгжилтийг хангах чиглэлээр анхаарч ажилласан.

Говь ХК нь байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын асуудлуудад онцгой ач холбогдол өгч ирсэн бөгөөд ТУЗ энэ чиглэлд хяналт, удирдлагын үүргээ тууштай хэрэгжүүлсэн. Тухайлбал, 4-р сарын ээлжит хурлаар БОНЗ-ын үйл ажиллагааны тайлантай танилцаж, ТУЗ-өөс баталсан тогтвортой хөгжлийн үүрэг амлалтын хэрэгжилтэд дүгнэлт хийж, удирдлагын багийг цаашдын үйл ажиллагаанд үр дүнтэйгээр чиглүүлэн ажилласан.

ТУЗ-ийн үндсэн үүргийн нэг болох хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн эрх ашиг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлд оны эхний хурлаар 2025 онд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх боломжтой холбоотой талуудын жагсаалт, хэлцлийн төсвийг баталж, батлагдсан төсөвт тусгагдаагүй сонирхлын зөрчилтэй хэлцлийг тухай бүр хурлаар хэлэлцэн зөвшөөрөл олгож, Эрсдэл, аудитын хороогоор дамжуулан хяналтыг хэрэгжүүлэн ажилласан.

Мөн энэ оны төлөвлөгөөнд тусгагдаагүй ч онцгой ач холбогдолтой асуудлын хүрээнд 7-р сард компанийн хэлбэрийг өөрчлөн хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) болох асуудлыг хэлэлцэхээр шийдвэрлэж, 2025 оны 9-р сарын 8-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулсан. Тус хурлаар ХХК болох саналыг оролцсон хувьцаа эзэмшигчдийн 99.99 хувийн саналаар дэмжин баталсан.

Энэхүү шийдвэртэй холбогдуулан Компанийн тухай хууль болон Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн “хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх”-ийг хэрэгжүүлэх нөхцөл үүссэнтэй холбоотойгоор ТУЗ-өөс холбогдох шийдвэр болон журмыг баталсан.

Оны сүүлийн хурал дээр компанид нэвтрүүлсэн томоохон системүүд болох SAP S/4 HANA ERP, MES (Manufacturing Execution System) болон Conveyor Belt (Дамжлагын систем)-ийн системийн хэрэгжилт, үр дүнтэй танилцан хяналт тавьж ажилласан.

Компанийн засаглалтай холбоотой дэлгэрэнгүй мэдээлэлтэй [“Жилийн тайлан 2025”](#) -ын 58-94-р нүүрнээс танилцах боломжтой.

6.

Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

2025 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Баримт бичгийн шинэчлэлт

"Говь" ХК-н Эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэх журам тогтолцоо шинэчлэгдэж эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг сайжруулж, урт хугацааны зорилгод хүрэхийн тулд дээд түвшний удирдлагуудтай хамтран, стратегийн түвшний эрсдэлийг тодорхойлж, удирдах шаардлага тулгарсан. Олон улсын практикт ашиглагдан түгээмэл болсон COSO ERM Framework-н 2017 онд шинэчлэгдэн гарсан "Enterprise Risk Management: Integrating with Strategy and Performance" тогтолцоог нэвтрүүлэхээр төлөвлөсөн. Үүний хүрээнд Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам, холбогдох хавсралт, маягт, эрсдэлийн үнэлгээ хийх гарын авлага, эрсдэлийн аппетитийн баримт бичиг зэргийг шинэчлэн боловсруулав.

Эрсдэлийн удирдлагын тогтолцооны хэрэгжилт

Байгууллагын эрсдэлийн удирдлагын сценений дагуу нийт газар, үйлдвэр, нэгжүүд учирч болзошгүй эрсдэлүүдээ тодорхойлох, үнэлэх, удирдах, хяналт мониторинг хийх, тайлагнах буюу тогтолцооны үе шатуудыг бүрэн хэрэгжүүлж, эрсдэлээс үүсэх үр нөлөөг хамгийн бага түвшинд байлгахаар удирдан ажилласаар байна.

Эрсдэлийн удирдлагын тогтолцооны тайлан

Эрсдэлийн удирдлагын шинэчилсэн журмын дагуу эрсдэлийн үнэлгээ болон эрсдэлийн мониторингийг жилд 2 удаа, эрсдэлийн аппетитийн хүрээнд үнэлэгдсэн өндөр түвшний эрсдэлүүдийг улирал тутам хянаж "Эрсдэлийн удирдлагын баг" болон "Эрсдэл аудитын хороо"-нд тайлагнан ажиллав.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТАЙЛАН

2025 оны 4-р улирлын байдлаар байгууллагын хэмжээнд нийт 324 идэвхтэй эрсдэл бүртгэлтэй байсан. Эдгээрээс 55 эрсдэлийг эрсдэлийн аппетитийн хэмжээнд хянан үнэлж, гүйцэтгэлийг тооцоолон гаргав.

Эрсдэл удирдах хариу арга хэмжээний төлөвлөлт боловсруулан хэрэгжүүлж, 2025 оны IV-р улирлын "Эрсдэлийн аппетит"-ийн мониторингоор АППЕТИТ ДАВСАН тохиолдол 0, АППЕТИТААС ГАРАХ ДӨХСӨН тохиолдол 2, АППЕТИТ ДОТОР БАЙГАА 53 эрсдэл байв.

		Үр нөлөө				
		Маш бага	Бага	Дунд	Их	Маш их
Нөлөөлөл	Маш их	8	17	5	0	0
	Их	2	16	8	1	0
	Дунд	16	30	28	3	0
	Бага	39	28	14	6	4
	Маш бага	57	18	16	5	3

Эрсдэлийн түвшин		Тоо	Эзлэх %
Маш их		0	0%
Их		17	5%
Дунд		161	50%
Бага		89	27%
Маш бага		57	18%
Нийт		324	100.0%

Захиргаа	Дизайн үйлдвэрлэл	Борлуулалт
Аппетит дотор байгаа 25	Аппетит дотор байгаа 18	Аппетит дотор байгаа 10
Аппетитаас гарах дөхсөн 1	Аппетитаас гарах дөхсөн 0	Аппетитаас гарах дөхсөн 1
Аппетитаас гарсан 0	Аппетитаас гарсан 0	Аппетитаас гарсан 0
Нийт 26	Нийт 18	Нийт 11

7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/																		
	ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД 0.05% Говь ХК-ийн ажилтнууд 12.51% Бусад 87.44% Таван Богд Холдингс НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО 780,112,500 НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ТОО 25,519 /2025.12.31-ний байдлаар/ НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД <table><tr><th rowspan="2">Хувьцаа эзэмшигчийн нэр</th><th colspan="2">2024.12.31</th><th colspan="2">2025.12.31</th></tr><tr><th>Хувьцааны тоо ширхэг</th><th>Эзэмшлийн хувь</th><th>Хувьцааны тоо ширхэг</th><th>Эзэмшлийн хувь</th></tr><tr><td>Таван Богд Холдингс ХХК</td><td>681,267,736</td><td>87.33%</td><td>682,106,188</td><td>87.44%</td></tr></table> Тайлант хугацаанд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт ороогүй бөгөөд хувь эзэмшил нь 0.11% нэмэгдсэн. Таван Богд Холдингс ХХК нь Таван Богд Группийн толгой компани юм. Таван Богд Групп нь бизнесийн 8 салбарт, 20 охин компани, 2 хөрөнгө оруулалттай компани, 13,000 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Үйл ажиллагааны чиглэлүүд: 1. Ноолуур 2. Автомашин, уул уурхайн тоног төхөөрөмж 3. Нийтийн хоол, түргэн хоолны үйлчилгээ 4. Банк & санхүү 5. Олон улсын худалдаа, үйлдвэрлэл 6. Барилга, бүтээн байгуулалт 7. Аялал, жуулчлал, зочлох үйлчилгээ 8. IT & эрүүл мэндийн үйлчилгээ <tr><td>8.</td><td> Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл </td></tr><tr><td></td><td> Олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй. </td></tr>	Хувьцаа эзэмшигчийн нэр	2024.12.31		2025.12.31		Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь	Таван Богд Холдингс ХХК	681,267,736	87.33%	682,106,188	87.44%	8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл		Олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.
Хувьцаа эзэмшигчийн нэр	2024.12.31		2025.12.31																
	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь															
Таван Богд Холдингс ХХК	681,267,736	87.33%	682,106,188	87.44%															
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл																		
	Олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.																		

9. Ногдол ашгийн мэдээлэл

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

Ногдол ашиг зарласан он	Хувьцааны тоо (ширхэг)	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг (төгрөг)	Нийт зарласан ногдол ашгийн дүн (төгрөг)	Ногдол ашиг тараалт
1997	7,801,125	153.80	1,199,813,025	2007 он хүртэлх ногдол ашгийг Говь ХК-ийн албан ёсны веб хуудсаар дамжуулан ирүүлсэн ногдол ашгийн хүсэлтийн дагуу шилжүүлж байна.
1998	7,801,125	150.00	1,170,168,750	
1999	7,801,125	166.00	1,294,986,750	
2000	7,801,125	100.00	780,112,500	
2001	7,801,125	20.16	157,270,680	
2002-2004	7,801,125	-	-	
2005	7,801,125	60.00	468,067,500	
2006	7,801,125	60.00	468,067,500	
2007-2009	7,801,125	-	-	Санхүүгийн үр дүнгээс шалтгаалан ногдол ашиг хуваарилаагүй.
2010	7,801,125	100.00	780,112,500	2010-2018 он хүртэлх ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн харилцдаг үнэт цаасны компаниуд руу 100% тараасан.
2011	7,801,125	100.00	780,112,500	
2012	7,801,125	125.00	975,140,625	
2013	7,801,125	130.00	1,014,146,250	
2014	7,801,125	140.00	1,092,157,500	
2015	7,801,125	140.00	1,092,157,500	
2016	7,801,125	200.00	1,560,225,000	
2017	7,801,125	220.00	1,716,247,500	
2018	780,112,500	6.80	5,304,765,000	
2019-2025	780,112,500	-	-	Санхүүгийн үр дүнгээс шалтгаалан ногдол ашиг хуваарилаагүй.

2025 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 2-р сарын 13-ны өдрийн №03 тоот тогтоолын дагуу 2025 оны санхүүгийн үр дүн нь компанийн ногдол ашгийн бодлогын 2.3-т заасан ногдол ашиг олгох нөхцөлийг хангаагүй буюу санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

ТОГТВОРТОЙ НООЛУУР-ГУРВАН ТАЛТ ХАМТАРСАН ТӨСӨЛ

Говь ХК нь Үйлдвэрлэл-Шинжлэх ухаан-Малчид хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх, малын эрүүл мэнд, арчилгаа маллагаа, үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй хийж гүйцэтгэх улмаар үржлийн шилмэл хээлтүүлэгчийг үржил селекцийн ажилд ашиглах болон малчдад ноолуур бэлтгэлийн технологийн зөв дадал эзэмшүүлэх замаар ноолууран түүхий эдийн чанарыг сайжруулж, түүнээс олох малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор "Тогтвортой ноолуур - Гурван талт төсөл"-ийг 2020-2025 оныг хүртэл 5 жилийн хугацаанд амжилттай хэрэгжүүлээ.



Төслийн санаачлагч, санхүүжүүлэгч:

Говь ХК

Төсөл хэрэгжсэн хугацаа:

2020 - 2025 он

Төслийн оролцогч талууд:

Хөдөө Аж Ахуйн Их Сургууль
Т.Балдан - ХААИС-ийн багш, Доктор, Дэд Профессор, төслийн зөвлөх
Б.Ганбат / ХААИС-ийн багш, Доктор, төслийн зөвлөх

Хөвсгөл аймаг, Их-Уул сум
Их-Уул сумын ЗДТГ
Их-Уул сумын Мал Аж Ахуйн Тасаг
54 малчин өрх

Баянхонгор аймаг, Жинст сум
Жинст сумын ЗДТГ
Жинст сумын Мал Аж Ахуйн Тасаг
52 малчин өрх

106 өрх

Төсөлд хамрагдсан малчин өрх

200 ухна

Шилмэл үүлдрийн ухна

19.2 тонн

Тогтвортой түүхий эдийн хэмжээ

96.6 сая₮

Өвөлжилтийн бэлтгэл өвс, тэжээл

25 сая₮

Малын ариутгал, халдваргүйжүүлэлт

2 Коллекц

Тогтвортой, хариуцлагатай коллекц



Түүхий эдийн гарц, чанарыг нэмэгдүүлэх, мал аж ахуйн тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор төслийн хүрээнд малын генетик сайжруулалтын ажлыг хэрэгжүүлсэн. Үүний хүрээнд өндөр ашиг шим, сайн генетик үзүүлэлттэй 200 толгой эцэг малыг сонгон худалдан авч, төслийн малчин өрхүүдийн сүрэгт ашиглуулан хээлтүүлэгт ашиглаж байна. Энэхүү арга хэмжээ нь сүргийн генетикийн чанарыг сайжруулж, ноолуурын гарц болон чанарын үзүүлэлтүүдийг нэмэгдүүлэхэд чиглэж байгаа бөгөөд хэрэгжилтийн үр дүнг үнэлэх зорилгоор жил бүр түүхий эдийн дээж авч лабораторийн шинжилгээ хийж, чанарын үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг тогтмол хянаж байна.

Тогтвортой, хариуцлагатай мал аж ахуй эрхлэхэд малын тавлаг байдал, эрүүл мэндийг хангах нь нэн чухал хүчин зүйл болдог. Иймээс төслийн хүрээнд хамтран ажиллаж буй малчин өрхүүдэд өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах зорилгоор өвс, тэжээлийн дэмжлэг үзүүлсэн. Мөн малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт болон паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор малын ариутгал, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг жил бүр зохион байгуулж, төслийн хамрагдсан малчин өрхүүдийн мал сүргийг тогтмол хамруулан ажиллаж байна. Эдгээр арга хэмжээ нь малын эрүүл мэндийг хамгаалах, ашиг шимийг нэмэгдүүлэх, улмаар чанартай түүхий эдийн тогтвортой нийлүүлэлтийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Мөн төслийн хүрээнд малчдын мэдлэг, чадавхыг бэхжүүлэх зорилгоор дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, түүний мал аж ахуйд үзүүлэх нөлөө болон түүнд дасан зохицох арга замуудын талаар сургалт, мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнээс гадна малчин өрхийн хөдөлмөрийн зохион байгуулалт, шийдвэр гаргалтад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш оролцоог дэмжих зорилгоор жендерийн мэдрэмжтэй хандлага, хөдөлмөрийн тэгш оролцооны талаарх ойлголтыг нэмэгдүүлэх сургалтуудыг зохион байгуулсан нь малчин өрхийн тогтвортой амьжиргаа болон хариуцлагатай мал аж ахуйн практикийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлж байна.

БЭЛЧЭЭРИЙН ШИЙДЭЛ ТӨСӨЛ

\$1 сая

Төслийн санхүүжилт
АХБ-ны Техникийн
туслалцаа

5 жил

2025 - 2029
төсөл хэрэгжих хугацаа

2 аймаг

Баянхонгор аймаг
Хөвсгөл аймаг

6+

Төсөл хэрэгжүүлэх
малчдын бүлэг



Зорилт 1:

Гураваас дээш тооны
бэлчээрийн менежментийг
Баянхонгор аймагт туршиж, 1
шийдлийг санал болгох

Зорилт 2:

Гураваас дээш тооны
бэлчээрийн менежментийг
Хөвсгөл аймагт туршиж, 1
шийдлийг санал болгох

Зорилт 3:

200 ба түүнээс дээш малчдад
санхүүгийн болон жендерийн
тухай сургалт орох

Зорилт 4:

200 ба түүнээс малчдад
бэлчээрийн менежментийн
сургалт орох

Зорилт 5:

Малчдыг цаг агаарын
урьдчилсан мэдээллийг цаг
алдалгүй авах боломжоор
хангах

**Special
Olympics
Mongolia**



Оролцоо, тэгш байдал, эв нэгдлийг дэмжих зорилгын хүрээнд манай байгууллага 2025 онд Итали улсын Турин хотод болсон Special Olympics World Games-д оролцсон Монгол Улсын баг тамирчдыг ноолууран бүтээгдэхүүнээр ханган, нийгмийн хариуцлагын хүрээнд ивээн тэтгэж хамтран ажиллав.



Компанийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлантай
“[Жилийн тайлан 2025](#)”-аас танилцах боломжтой.

11.

Үнэт цаас гаргагчийн бүтэц (толгой, охин, хараат, зэргэлдээ компаниуд, тэдгээрийн хувь эзэмшлийн талаар), холбоотой талуудын санхүүгийн гүйлгээний талаарх мэдээлэл;

ГОВЬ ГРУППИЙН БҮТЭЦ



2025 ОНЫ ХОЛБООТОЙ ТАЛУУДАЙ ХИЙСЭН АЖИЛ ГҮЙЛГЭЭ БА ҮЛДЭГДЭЛ /мянган төгрөг/

ХОЛБООТОЙ ТАЛ

Хувьцаа эзэмшигчид
Таван Богд Холдингс ХХК
Зэргэлдээ охин компаниуд
Бусад холбоотой талууд

ХОЛБОО ХАМААРАЛ

Дээд шатны хянагч компани
Дээд шатны хянагч компанийн охин компаниуд
Хараат, хамтарсан компаниуд, үндсэн удирдлагын багийн гишүүдийн хяналтан дор байдаг бусад холбоотой талууд

1.ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ДАНСНЫ ҮЛДЭГДЭЛ

Тайлант хугацааны эцэст холбоотой талуудын үлдэгдэл дараах байдалтай байна:

	2024	2025
Холбоотой талуудад өгсөн урьдчилгаа		
Дээд шатны хянагч компани	-	139,975
Зэргэлдээ охин компаниуд	-	10,000,000
Холбоотой талуудаас авах авлага		
Дээд шатны хянагч компани	70,162	2,289
Зэргэлдээ охин компаниуд	-	1,500
Холбоотой талд өгөх өглөг /Богино хугацаат/		
Дээд шатны хянагч компани	25,309,850	-
Зэргэлдээ охин компаниуд	-	10,945
Холбоотой талаас авсан зээл		
Бусад холбоотой талууд	-	5,442,091

Холбоотой талуудын дансны үлдэгдэлд барьцаагүй ба найдваргүй авлагын сан байгуулаагүй.

2.ХОЛБООТОЙ ТАЛУУДАЙ ХИЙСЭН АЖИЛ ГҮЙЛГЭЭ

Дараах ажил гүйлгээг Группийн толгой компани болох Таван Богд Холдингс ХХК-тай хийсэн байна:

	2024	2025
Дээд шатны хянагч компаниас авсан урьдчилгаа	177,957,846	148,747,327
Дээд шатны хянагч компаниас авсан урьдчилгааны төлбөр	183,297,808	174,057,177
Дээд шатны хянагч компаниас авсан худалдан авалт	1,379,271	1,548,104
Дээд шатны хянагч компанид хийсэн борлуулалт	22,792	19,215
Дээд шатны хянагч компанид төлөх хүүгийн зардал	4,378,356	4,076,648
Дээд шатны хянагч компанид төлсөн хүүгийн зардал	4,378,356	4,076,648

Дараах ажил гүйлгээг Группийн нэгдсэн хяналтад байдаг бусад холбоотой талуудтай хийсэн байна:

	2024	2025
Бусад холбогдох талуудаас авсан санхүүжилт	325,232,000	214,477,000
Бусад холбогдох талуудаас авсан санхүүжилтийн эргэн төлөлт	335,862,000	214,477,000
Бусад холбоотой талуудад өгсөн зээл	-	20,000,000
Бусад холбоотой талуудад өгсөн зээлийн эргэн төлөлт	-	10,000,000
Бусад холбоотой талуудаас авсан худалдан авалт	1,715,066	3,380,448
Бусад холбоотой талд хийсэн борлуулалт	174,981	880,593
Бусад холбоотой талаас авсан түрээсийн орлого	304,733	585,361
Бусад холбоотой талаас авсан хүүгийн орлого	-	1,300,247
Бусад холбоотой талд төлөх хүүгийн зардал	2,575,220	1,210,492
Бусад холбоотой талд төлсөн хүүгийн зардал	2,575,220	1,210,492

Дараах ажил гүйлгээг дээд шатны хянагч компанийн хараат компани болох ХААН банктай хийсэн байна:

	2024	2025
Хаан банкнаас авсан санхүүжилт	148,311,216	118,211,755
Хаан банкнаас авсан санхүүжилтийн эргэн төлөлт	169,011,431	112,544,995
Хаан банканд хийсэн борлуулалт	231,895	1,244,815
Хаан банкинд төлөх хүүгийн зардал	478,232	512,712
Хаан банкинд хүүгийн төлбөр төлөх	531,164	423,145

Бүх холбоотой талын гүйлгээ нь харилцан тохиролцсон нөхцөлөөр хийгдсэн.

3.ХОЛБООТОЙ ТАЛУУДАЙ ХИЙСЭН АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ХАРЬЦУУЛАЛТ

• Санхүүжилтийн зардал	2024	2025
Нийт санхүүжилтийн зардал	30,117,480	34,755,789
Холбоотой талаас авсан санхүүжилтийн зардал	7,431,806	5,799,852
Эзлэх хувь /холбоотой тал/	25%	17%




Говь ХК нь 2025 онд холбоотой талын санхүүжилтийн зардалд 5,799,852 мянган төгрөг төлсөн нь нийт санхүүжилтийн зардлын 17%-ийг эзэлж байна. Холбоотой талаас авсан санхүүжилтийн зардлын дундаж төгрөгийн хүү нь 14.4% байна.


Жич: Холбоотой тал нь олгосон санхүүжилтэд санхүүгийн харьцаа болон барьцаа хөрөнгө шаарддаггүй.

• Худалдан авалт	2024	2025
Нийт худалдан авалт	94,696,681	92,782,965
Гадаадын худалдан авалт	34,037,838	23,935,336
Дотоодын худалдан авалт	60,658,842	68,847,629
Холбоотой талаас авсан худалдан авалт	2,960,699	4,928,552
Эзлэх хувь/нийт худалдан авалтад холбоотой талын эзлэх хувь/	3.1%	5.3%
Эзлэх хувь/дотоодын худалдан авалтад холбоотой талын эзлэх хувь/	4.9%	7.2%

НИЙТ ХУДАЛДАН АВАЛТ



ДОТООДЫН ХУДАЛДАН АВАЛТ



Говь ХК нь 2025 онд холбоотой талаас авсан худалдан авалтын дүн 4,928,552 мянган төгрөг буюу нийт худалдан авалтад эзлэх хувь 5.3% байна /2024 онд 3.1%/.

Холбоотой талаас авсан худалдан авалт нь зах зээлийн үнээр хийгдсэн.

Жич: Бүх холбоотой талын гүйлгээ нь Говь ХК-ийн "Худалдан авалтын бодлого", "Захиалга хүлээн авах, худалдан авах, хүлээлгэн өгөх журам", "Ажил үйлчилгээ худалдан авах журам", "Сонгон шалгаруулах хорооны журам"-ын дагуу үнийн харьцуулалт судалгааг хийн, сонгон шалгаруулалтын хороогоор орсны үндсэн дээр зах зээлийн үнээр хийгдсэн бөгөөд харилцан давуу байдлыг олгоогүй болно.

12.	Үнэт цаас гаргагч нь (Банк, Даатгал, Банк бус санхүүгийн байгууллага, болон Үнэт цаасны компани) төлбөрийн чадвар, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт																																	
	Дээрх төрөлд хамаарахгүй.																																	
13.	Үнэт цаас гаргагч нь өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авч, хүчингүй болгох замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бууруулах, компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтрэх, компанийн өр нь хоёр жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болох нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлж, энэхүү нөхцөл байдал үүссэн тохиолдолд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл																																	
	АШГИЙН ҮЗҮҮЛЭЛТ <table><tr><th>Үзүүлэлт</th><th>2024</th><th>2025</th></tr><tr><td>Үйл ажиллагааны ашгийн хувь</td><td>-24%</td><td>-11%</td></tr><tr><td>EBITDA хувь</td><td>-22%</td><td>-19%</td></tr><tr><td>Цэвэр ашгийн хувь</td><td>0%</td><td>-1%</td></tr></table> ӨР ТӨЛБӨРИЙН /EBITDA/ <table><tr><th>Үзүүлэлт</th><th>2024</th><th>2025</th></tr><tr><td>Өр төлбөрийн /EBITDA/</td><td>5.7</td><td>5.9</td></tr></table> 2025 онд компанийн ашигт ажиллагааны үзүүлэлтүүд 2024 онтой харьцуулахад мэдэгдэхүйц сайжирч, үйл ажиллагааны ашгийн хувь 2 пунктээр, EBITDA маржин 13 пунктээр, цэвэр ашгийн түвшин алдагдлаас ашигт шилжсэн нь үндсэн үйл ажиллагааны ашиг болон зардлын удирдлага сайжирч, эерэг өөрчлөлт гарч байгааг илтгэж байна. Өрийн удирдлага тогтвортой түвшинд хадгалагдаж, Өр/EBITDA харьцаа 5.9 болж сайжирсан нь санхүүгийн чадаах бэхжиж байгааг харуулж байна. НИЙТ ХӨРӨНГӨ /тэрбум төгрөг/ <table><tr><th>Үзүүлэлт</th><th>2024</th><th>2025</th></tr><tr><td>Нийт хөрөнгө</td><td>306.3</td><td>302.2</td></tr><tr><td>Эздийн өмч</td><td>1.5</td><td>-22.2</td></tr></table> БАРАА МАТЕРИАЛЫН ЭРГЭЦ /хоног/ <table><tr><th>Үзүүлэлт</th><th>2024</th><th>2025</th></tr><tr><td>Бараа материалын эргэц</td><td>358</td><td>353</td></tr></table> 2025 онд компанийн нийт хөрөнгө 302.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 1 хувиар буурсан нь хөрөнгийн хэмжээ тогтвортой байгааг илтгэж байна. Эздийн өмч -22.2 тэрбум төгрөгт хүрсэн нь хуримтлагдсан алдагдлын нөлөөлөл хэвээр байгааг харуулж байна. Гэсэн хэдий ч компанийн зүгээс эргэлтийн хөрөнгийн удирдлагыг сайжруулах, ялангуяа түүхий эд, бараа материалын нөөцийг бууруулах чиглэлд бодит арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд бараа материалын эргэлт 353 хоног болж, өмнөх оноос 1%-аар сайжирсан байна. Энэ нь хөрөнгийн ашиглалтыг нэмэгдүүлж, мөнгөн урсгалын үр ашгийг сайжруулах эерэг хандлагыг илэрхийлж байна.	Үзүүлэлт	2024	2025	Үйл ажиллагааны ашгийн хувь	-24%	-11%	EBITDA хувь	-22%	-19%	Цэвэр ашгийн хувь	0%	-1%	Үзүүлэлт	2024	2025	Өр төлбөрийн /EBITDA/	5.7	5.9	Үзүүлэлт	2024	2025	Нийт хөрөнгө	306.3	302.2	Эздийн өмч	1.5	-22.2	Үзүүлэлт	2024	2025	Бараа материалын эргэц	358	353
Үзүүлэлт	2024	2025																																
Үйл ажиллагааны ашгийн хувь	-24%	-11%																																
EBITDA хувь	-22%	-19%																																
Цэвэр ашгийн хувь	0%	-1%																																
Үзүүлэлт	2024	2025																																
Өр төлбөрийн /EBITDA/	5.7	5.9																																
Үзүүлэлт	2024	2025																																
Нийт хөрөнгө	306.3	302.2																																
Эздийн өмч	1.5	-22.2																																
Үзүүлэлт	2024	2025																																
Бараа материалын эргэц	358	353																																
14.	Тайлант хугацаанд эргүүлэн худалдан авсан халаасны хувьцааны тоо, ширхэг, ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлсэн, үнэт цаасаар урамшуулал олгосон талаарх мэдээлэл																																	
	Тайлант хугацаанд байхгүй.																																	
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:																																		
Овог, нэр: М.Сэлэнгэ Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Гарын үсэг: Огноо: 2026 оны 3-р сарын 30-ны өдөр																																		